

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 11 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар A/304 A/699

Улаанбаатар

Соогооаны хэм ХЭМЖЭЭНИЙ
актын улсын нэгдсэн санд
2018 оны 12. сарын 05.-ны
өдрийн 4053 дуггарт бүртгэв.

Заавар, маягт батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.3.3 болон 3.2.2.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааврыг нэгдүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягтыг хоёрдугаар, Хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягтыг гуравдугаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх, төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг лавлагаа төвүүд болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төвүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга захирал нарт тус тус даалгасугай.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах, цэцэрлэг сургуульд хамрагдалтыг сайжруулахад мэргэжил арга зүй, хүний нөөц, тохируулгат орчныг бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад тус тус даалгасугай.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст даалгасугай.
6. Зааварт холбогдох маягтуудыг боловсруулж, албажуулан нэгдсэн бүртгэл мэдээллийн санд оруулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар (Т.Ням-Очир), Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар (Б.Дуламжав), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газар (М.Баттувшин)-т тус тус үүрэг болгосугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамдын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

9. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд (хуучин нэрээр), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд (хуучин нэрээр), Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/05, А/14, 16 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ХӨГЖЛИЙН ЦОГЦ ДЭМЖЛЭГ

ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. ЗААВРЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

1.1 ЗОРИЛГО, ХЭРЭГЛЭГЧИД

Энэхүү мэргэжил арга зүйн баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц тусlamж үйлчилгээ, хөгжлийн дэмжлэгт хамруулах үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс (цаашид "Комисс" гэх), орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид "Салбар комисс" гэх)-ын гишүүд, энэ үйл явцад оролцдог аймаг, нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Боловсрол, соёлын газрын мэргэжилтнүүд, цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, эмч нар, Эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, амаржих газар, клиник, өрх, сумын эмч, сувилагчид, эцэг эх, гэр бүлийн мэдлэг хандлагыг сайжруулж, үйлчилгээ үзүүлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд лавлагаа болгон мэргэжил, арга зүйгээр хангах зорилготой.

1.2 ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Одоогоор хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлж, хөгжлийн дэмжлэгт хамруулахад баримтлах мэргэжлийн удирдамж аргачлал байхгүй байгаа тул Комисс болон аймаг, дүүргийн Салбар комиссууд нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай мэдлэг хандлага, үйл ажиллагаа, тогтолцооны талаар нэгдсэн ойлголтыг бүрдүүлэх зорилгоор энэхүү зааврыг боловсруулав. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлийн эрхийг хамгаалж, хэрэгцээг хангахын тулд бүх түвшний оролцогч талууд нэгдсэн ойлголтой байж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа нь уялдаа холбоотой, тогтвортой байх шаардлагатай.

Хөгжингүй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлж, боловсролд эрт хамруулан сургаж тэднийг бусдын адил нийгэмд оролцох боломжийг бурдүүлсэн тогтолцоо хэдийнээ бий болсон байна.

2016 онд Монгол Улсын Их Хурлаас Соёрхон баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусгай бүлэг болгон тусгасан боловч нэн шаардлагатай аргачлал, зааваргүйгээр хуулийг хэрэгжүүлэх боломжгүй юм.

Монгол улсын Засгийн газраас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн З дахь зорилтод (3.1.3.3) "... хүүхдийг эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулж, илэрсэн хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд дэмжлэг үзүүлэх удирдамж боловсруулан хэрэгжүүлнэ" гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн дээрх хууль, эрх зүй, бодлогыг бодитой хэрэгжүүлэхэд нотолгоонд суурилсан үйл ажиллагаа, олон улсад нийтлэг тогтолцоог бурдүүлэхэд лавлагаа болох мэргэжил арга зүйн аргачлал, заавар хэрэгтэй юм

Энэхүү зааврыг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн Хөвсгөл аймаг, Баянгол дүүрэгт хэрэгжүүлсэн туршилага дээр үндэслэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар, Комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбоо, Монголын Дауны холбоо, Монголын Аутизмын холбоо, БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газар, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газрын холбогдох мэргэжилтнүүд, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Боловсролын хүрээлэн, МУБИС-ын эрдэмтэн багш нар олон удаа хамтран хэлэлцэж, зөвшилцсөний үндсэн дээр боловсруулсан болно.

ХОЁР. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

2.1 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТАЛААРХ ДЭЛХИЙ ДАХИНЫ ЧИГ ХАНДЛАГА

Манай гариг дээр нэг тэрбум гаруй хүн хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй амьдарч байна. ДЭМБ-ын судалгаанаас үзвэл 15-аас дээш насны үйл ажиллагааны ноцтой алдагдалтай 110-190 сая (2,2-3,8 хувь) хүн байгаа аж¹. Түүнчлэн 15 хүртэлх

¹ World report on disability 2011. WHO & WB



насны 20 хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна².

НҮБ-ын ерөнхий ассамблейгаас баталсан Хүүхдийн Эрхийн Конвенцид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь тусгай халамж болон ижил тэгш харьцааг хүлээн авах эрхтэй, боловсрол бол хүний үндсэн эрх, хүүхэд бүр өөрийн онцлогт тохирсон орчноор хангагдах эрхтэй хэмээн заасан.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай" НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, алагчлалыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох талаар тодорхой тэмдэглэсэн байна³. Үүнд:

2012 онд БНСУ-ын Инчеон хотод зохион байгуулсан Ази, Номхон далайн бүс нутгийн Төр засгийн тэргүүн нарын чуулга уулзалтаар манай бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Сайд нарын тунхаглал"-ыг гаргаж, "Эрхийг бодит болгоё" хэмээх стратегийг тус тус баталсан⁴. Тус стратегийн гол үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх талын эрхийг хамгаалахад Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын Засгийн газрын хүүхдийн эрт оролцоо ба боловсролд хамруулалтыг өргөжүүлэх⁵" хэмээх тавдугаар нүүрэг амлалтыг бодитой болгоход чиглэсэн юм. Стратегийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оролцоо ба боловсролд хамруулалтыг өргөжүүлэх" хэмээх тавдугаар зорилгын хүрээнд нэгдүгээрт, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг төрсөн цагаас сургуульд орох хүртэлх хугацаанд аль болох эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах; хоёрдугаарт, бага, дунд сургуульд хамрагдалтын тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгожээ⁶.

Дээр дурдсан олон улсын конвенц, хамтарсан тунхаглалын зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс орон бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрч, тэдний оролцоог хангахад тодорхой хүчин чармайлт гаргах хэрэгтэй юм.

² Report The State of the World's Children 2013 UNICEF (Children with Disabilities)

³ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (артикл 24.2)

⁴ Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан "Эрхийг бодит болгоё" Инчеоны стратеги, хуудас 10

⁵ Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан "Эрхийг бодит болгоё" Инчеоны стратеги, хуудас 34

⁶ Ази номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан "Эрхийг бодит болгоё" Инчеоны стратеги, 5 дугаар зорилго, Зорилт 5а, 5б, хуудас 34-35



2.2 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ТӨР, ЗАСГААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, САНААЧИЛГА

Монгол улс НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцид 1990 онд анхлан нэгдсэн орнуудын нэг⁷, мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцид 2009 онд нэгдэн орсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин, нөхцлийг нь хүүхэд бүрийн онцлогт тохируулан хангах үүргийг Монгол улсын засгийн газар хүлээдэг. Эдгээр конвенцуудын үзэл санааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын адил тэгш боломжийг хүртэх хууль эрх зүйн тогтолцоо бүрдүүлэхэд онцгой ач холбогдол бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийг 2016 оны 2 дугаар сард УИХ-аар батлан хэрэгжүүлж байна.

Тус хуулийн 28 дугаар зүйл нь бүхэлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэхийн зэрэгцээ 37 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс”-ыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулахаар хуульчилсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, дэмжихэд томоохон ахиц дэвшил гарсан болно. Комисс нь 16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэн хөгжлийн дэмжлэгийг аль болох бага насанд нь үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилготой (Энэ нь саяхныг болтол үйлчилж байсан Эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагаанаас эрс ялгаатай).

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “...Бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх” талаар заасан байдаг.

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг тусгасан байна. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 185 дугаар

⁷ <https://treaties.un.org/doc/Publication/MTDSG/Volume%20I/Chapter%20IV/iv-11.en.pdf>

⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 14 дүгээр зүйл: Сурч боловсрох эрх, 14. 1. 3



тогооولد “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгоходо нэг сурагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцно. Энэхүү заалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарна” гэж заасан.

2.3 МОНГОЛ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БАЙДАЛ

Үндэсний статистикийн хорооны 2017 оны албан ёсны тайландаа дурдсанаар Монгол улсын хүн амын 3.2 хувь нь /103630/ ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 11 орчим хувийг /11453/ 0-17 насны хүүхэд эзэлж байна. Эдгээр хүүхдийн 11.1 хувь нь харааны, 7.4 хувь нь хэл ярианы, 7.4 хувь нь сонсголын, 17.4 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 22.4 хувь нь хөдөлгөөний, 23.6 хувь нь хавсарсан бэрхшээлтэй гэсэн мэдээлэл байдаг⁹.

Комиссын тайлангаас үзвэл 2017 оны байдлаар аймаг, дүүргийн Салбар комиссууд нийт 3949 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг, 3487 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлж, 239 хүүхдийг СӨБ-д, 314 хүүхдийг ЕБС-д, 11 хүүхдийг боловсролын бусад үйлчилгээнд холбон зуучилж, хамруулсан байна.

Монгол улсад 1964 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль байгуулах ажлын эхлэл тавигдсан бөгөөд тусгай сургуульд ажиллах боловсон хүчнийг гадаадад сургаж ирсэн. Одоогоор нийслэлд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай 6 сургууль ажиллаж байгаагийн дөрөв нь (25, 55, 63, 70 дугаар сургуулиуд) оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хэрэгцээт хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлж байгаа хэдий ч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД БАГА НАСАНД НЬ ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

Хүүхдийн эхийн хэвлэйд бүрэлдэх үеэс найман нас хүртэлх үеийг бага нас гэдэг (ДЭМБ)¹⁰. Бага нас бол хүүхэд бүрт насан туршийн боловсрол, оролцооны эхлэлийг тавих үе, мөн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл үүсэхээс сэргийлэх боломж нээлттэй байдаг онцгой чухал “ценх” үе бөгөөд энэ үед хүүхдийн хөгжил, ялангуяа

⁹ Үндэсний статистикийн хорооны тайлан, 2017

¹⁰ Early Childhood Development and Disability: A discussion paper WHO/UNICEF

уураг тархины хөгжил маш эрчимтэй хөгжиж, цаашдын өсөлт, хөгжлийн суурь болдог (WHO 2012, 18).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэхийн чухлыг ... "тухайн хүний хэрэгцээ боломжид нийцсэн олон мэргэжилтнүүдийн үнэлгээг үндэслэн хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг аль болох эрт эхлэх хэрэгтэй¹¹" гэж тэмдэглэсэн байdag.

Хөгжлийн бэрхшээлийн тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх талаарх ойлголт цаг хугацааны явцад нилээд хувьсан өөрчлөгджээ. ДЭМБ-ын "Үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилал: Хүүхэд залуучуудын хувилбар"-т хөгжлийн бэрхшээлийг цэвэр биологийн эсвэл нийгэм талаас нь харах хандлагаас татгалзаж, харин эрүүл мэндийн байдал, орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэж үздэг¹².

Монгол улсад хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр дүнд өвчлөл, нас бараг тууштай буурч байгаа хэдий ч хүүхдийн хөгжлийг хянах, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг бага насанд нь илрүүлэн хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо одоогоор бүрдээгүй байна.

Хүүхдийг цэцэрлэг, сургуульд орохыг угтуулан эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулан аливаа өвчин, эмгэг болон хөгжлийн хоцрогдлын эрсдлийг тухай бүрт илрүүлэн цаашдын тусlamж, үйлчилгээ, хөгжлийн дэмжлэгийг цаг алдалгүй үзүүлэх тогтолцоог бий болгосноор "Хүүхдийн эрхийн конвенц", "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц"-ийн үзэл санаанд үндэслэсэн хууль, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

3.1 ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ, ЭРТ ОРОЛЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Хөгжлийн дэмжлэг, эрт оролцооны үйлчилгээнд хамруулах үйл явцыг Бүдүүвч 1-д нэгтгэн харуулав. Үүнд:

- 1) Эрт илрүүлэлт
- 2) Оношилгоо, үнэлгээ
- 3) Хөгжлийн дэмжлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх
- 4) Хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ ордог.


¹¹ UNCRPD Article 26 (a).

¹²http://apps.who.int/iris/bitstream/10665/75355/1/9789241504065_eng.pdf (Early Childhood Development and Disability:A discussion paper page 7)




Бүдүүвч 1. Хөгжлийн дэмжлэг эрт оролцооны үйлчилгээнд хамруулах үйл явц

Тус бүдүүвчид холбогдох байгууллагуудын оролцоо, уялдаа холбоог тусгав



3.2 ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, БЭРХШЭЭЛИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭЛТ

Бүдүүвч 2. Эрт илрүүлэлт



Хүүхдийг эхийн хэвлийд байх үед болон нярай, бага насанд зохистой арга хэмжээ авснаар хөгжлийн бэрхшээл үүсэхээс 70 хувь сэргийлэх боломжтой, гэвч



хөгжлийн хоцрогдолтой 9 сартай хүүхдүүдийн 9 хувь, 24 сартай хүүхдүүдийн дөнгөж 12 хувь нь шаардлагатай үйлчилгээг авч байна гэсэн судалгаа байдаг¹³.

Хөгжлийн хоцрогдлын илт эрсдэлтэй хүүхдэд цаг алдалгүй хөгжлийн дэмжлэг үзүүлэх, чадвар алдалтыг багасгах, эцэг эхийн оролцоог сайжруулахад эрт илрүүлэх тогтолцоо зайлшгүй шаардлагатай.

3.2.1 Эрт илрүүлэлт – эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг

Эрт илрүүлэлт гэдэг нь зорилтот бүлгийн эрүүл хүн амыг нэгдсэн үзлэг эсвэл шинжилгээнд хамруулж тэднээс тодорхой өвчин, эмгэгийн эрсдэлтэй хүнийг олж илрүүлэн нарийвчилсан оношилгоо, үнэлгээ, шинжилгээ хийж баталгаажуулан холбогдох тусlamж үзүүлэхэд чиглэсэн арга юм. Энэ аргыг үе тэнгийн эрүүл хүүхдүүдийг эрүүл мэндийн иж бүрэн үзлэг, шинжилгээнд нэгдсэн журмаар хамруулан аливаа эмгэг, өөрчлөлт, хоцрогдлыг олж илрүүлэх, ингэхдээ зөвхөн нэг эмгэгийг (сонсгол, хараа, цусан дахь хар тугалгын хэмжээ, сурьеэ г.м.) илрүүлэх, эсвэл иж бүрэн үзлэгээр хэд хэдэн эмгэгийг (бие махбодын эмгэг, өвчин болон хөгжлийн хоцрогдлыг хамтад нь) илрүүлэхэд ашиглана.

Хүүхдийн ёсөлт, хөгжлийг дэмжих нь эрүүл мэндийн тэргүүлэх асуудлуудын нэг бөгөөд ингэхдээ дараах гурван аргыг цогцоор ашигладаг:

- Хүүхдийн хөгжлийг тодорхой насанд нь хянах;
- Үе тэнгийн хүүхдүүдийг нэгдсэн үзлэгт зэрэг хамруулан, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх;
- Хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх талаар эцэг эх гэр бүлд зөвлөгөө өгөх;

Хүүхдийн хөгжлийг хянахдаа хүүхэд бүрийг тодорхой насанд нь эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулж эрсдэлтэй хүүхдийг илрүүлэн холбогдох тусlamж, үйлчилгээ болон хөгжлийн дэмжлэг үзүүлнэ. Цогц гэдгийн учир нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг хамтад үнэлнэ гэсэн үг юм. Хөгжингүй орнуудад хүүхдийг 9, 18, 24 болон 30-36 сартайд эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгт хамруулдаг (CDC зөвлөмж).

3.2.2 Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах

Өрх, сумын эрүүл мэндийн төв нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулж, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийг бага насанд нь олж илрүүлэн холбогдох үйлчилгээнд илгээнэ.

¹³ Feinberg, E., Silverstein, M., Donahue, S. & Bliss, R. (2011). The impact of race on participation in Part C Early intervention services. Journal of Developmental and Behavioral Pediatrics, 32(4), 1-8



Үе тэнгийн хүүхдүүдийг нэгэн ижил аргачлалаар, тухайн насанд нь тохирсон асуумжийн дагуу нэгдсэн журмаар үзлэг зохион байгуулах нь хүүхдүүдийг өөр хооронд нь харьцуулж, хөгжлийн үзүүлэлтүүдийг дүгнэх боломжийг бүрдүүлдэг.

Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулах насыны товлол

18 сартай хүүхэд: Харилцааны болон хэл ярианы хоцрогдол 18 сартайд мэдэгддэг. Хөнгөн хэлбэрийн хөдөлгөөний хоцрогдол мэдэгдэхгүй байсаар 18 сартайд тодорхой илэрдэг. Мөн 18 сартайд хүүхдийн хөдөлгөөний хоцрогдлыг сэргээн засах, хэл ярианы хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд хамгийн үр дүнтэй байдаг.

36 сартай хүүхэд: Энэ насанд хүүхдийн хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэлтүүдийг хэмжих боломжтой. Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгээр аливаа хөгжлийн хоцрогдлыг илрүүлж, цаашид үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд илгээх боломжтой юм. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх тухайн насыны асуумжийг эх, эцэг хариулж бичих нь төдийлөн төвөгтэй биш. Хүүхэд цэцэрлэгт явж байгаа бол багш нь үе тэнгийнхэнтэй нь жишиж үзээд хөгжлийн хоцрогдол, өөрчлөлтийг илрүүлэх ч тохиолдол гардаг.

Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийхдээ дараах асуудлуудыг онцгой анхаарна. Үүнд:

- 1) Юуны өмнө хүүхэд бүрийг "Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"-тэй болгох.
Бага насыны хүүхдийн асран хамгаалагчид, гэр бүл, цэцэрлэгийн багш нар дэвтрэйг ашиглаж чаддаг байх хэрэгтэй;
- 2) Эцэг, эх, асран хамгаалагчдын санаа, сэтгэгдлийг сайтар ойлгож мэдрэх, тэднээс хүүхдийнх нь тухай зэлдгээр асууж тодруулах;
- 3) Хүүхдийн зан төрхийг олон талаас нь нягт нямбай ажиглаж шинжих;
- 4) Хүүхдэд бодит үзлэгийг бүрэн хийх явцдаа эрүүл мэнд ба хөгжлийг цогцоор нь үзэж үнэлэх;
- 5) Хүүхдийн үзлэгийн явцад илэрсэн бүх өөрчлөлтийг нямбай тэмдэглэж, дүгнэх;
- 6) Сонсгол, хараа, хэл ярианы хоцрогдолтой байх нь бусад хоцрогдлын шалтгаан болдгийг ямагт бодож үзэх;
- 7) Хүүхдийн эцэг эхтэйгээ хэрхэн харилцаж байгааг хөндлөнгөөс анхааралтай ажиглах;



Хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэг нь ямагт гэр бүл төвтэй байх ба дараах зургаан бүрэлдэхүүнтэй:

- 3.2.2.1 Эмч, сувилагч нар Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх хөх хуудасны тэмдэглэгээг шалгангаа асран хамгаалагчаас асуумжийн дагуу нэг бүрчлэн асуух, хүүхдийнхээ хөгжлийн талаар эцэг эхийн анзаарч зовнисон асуудлыг илрүүлэх;
- 3.2.2.2 Хүүхдийн хөгжлийн явцын талаарх мэдээллийг няմбай тэмдэглэж хөтлөх;
- 3.2.2.3 Хүүхдэд бодит үзлэг хийхдээ, хөгжлийг анхааралтай ажиглах;
- 3.2.2.4 Эрсдэлт хүчин зүйлс, хамгаалагч хүчин зүйлүүдийг олж тогтоох;
- 3.2.2.5 Тухайн үзлэгийн үед илэрсэн шинж тэмдгүүдийг нягт няմбай тэмдэглэж, баримтжуулах ба цуглуулсан мэдээллээ нэгтгэн дүгнэнэ;
- 3.2.2.6 Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, БОЭТ зэрэг эрүүл мэндийн байгууллагад оношуулхаар илгээх ба тэдгээр байгууллага нь шаардлагатай хүүхдийг Салбар комисст илгээнэ.

Бүрэлдэхүүн тус бүрийг доор дэлгэрүүлэн тайлбарлав.

3.2.2.1 Эмч, сувилагч нар Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөх хуудасны тэмдэглэгээг шалгангаа эцэг, эхээс асуумжийн дагуу нэг бүрчлэн асуух ба хүүхдийн хөгжлийн талаар эцэг, эхийн анзаарч зовнисон асуудлыг илрүүлэх:

Үзлэг хийхэд ашиглах үзлэгийн маягтад хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийн гол үзүүлэлтүүдийг асуултуудын дагуу бөглөж бичнэ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн эцэг эхэд зориулсан хөх хуудас дахь "...Хүүхдээ өсгөж бойжуулахад санаа зовнисон асуудал байна уу?, Зан төрхийн талаас болон аливаа зүйлийг сурхад?" гэж асуун хариултыг анхааралтай сонсонгоо хөгжлийн талаарх чухал мэдээллийг олж авдаг. Зарим үед хөгжлийн хоцрогдол нь зан төрхөөр илэрхийлэгддэг. Эцэг, эхийн үнэтэй мэдээлэл юм. Хүүхэд өвчний учир, дархлаажуулалт болон бусад шалтгаанаар эрүүл мэндийн байгууллагад хандах үед энэ асуудлыг мөн анхаарах хэрэгтэй.

3.2.2.2 Хүүхдийн хөгжлийн явцын талаарх мэдээллийг нягт няմбай тэмдэглэж, хөтлөх:

Өмнөх үзлэгээс хойш хүүхдийн хөгжилд гарсан өөрчлөлтийн талаар эцэг, эхээс асуух нь хүүхдийн хөгжил хэвийн бус байгааг мэдэх ач холбогдолтой. Ялангуяа Эх,



хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн "... хүүхэд өөрөө явж чадаж байна уу?" гэх мэт тухайн насанд тохируулсан асуумж чухал үүрэгтэй. Хөгжлийн хоцрогдолтой эсэхийг тогтоохоос гадна гаж хөгжлийг шалгах шаардлагатай.

Тархины саажилт, аутизмын хүрээний эмгэгүүдийн үед хөгжлийн явц нь өвөрмөц явагддаг. Түүнчлэн зарим эмгэгийн үед хөгжлийн хоцрогдлын түвшин харилцан адилгүй илрэх тохиолдол байдаг. Тухайлбал, зарим оюуны хоцрогдол, аутизмтай хүүхдүүдийн хөдөлгөөний чадвар ердийн атлаа хэл ярианы хоцрогдолтой байдал ажиглагддаг. Гэтэл доод мөчний саажилттай хүүхэд хөдөлгөөний чадваргүй боловч хэл ярианы хөгжил хэвийн байдаг. Явцын дунд чадвар нь улам доройтсоор байх нь хүүхдийн мэдрэлийн үйл ажиллагаатай холбоотой хөгжлийн ноцтой шинж юм.

3.2.2.3. Хүүхдэд бодит үзлэг хийхдээ хөгжлийг анхааралтай ажиглах:

Эмч, мэргэжилтнүүд хүүхдийн хөгжлийн аливаа асуудлыг анзаарч илрүүлэх мэдлэг чадвар эзэмшсэн байх ёстой. Бодит үзлэгээр бие эрхтэний болон хөгжлийн үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн шалгах нь хүүхдийн хөгжлийг хянах тандах үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн болно. Хүүхдийн нас бага байх тусам хөгжлийн хоцрогдол нь хөдөлгөөн, биеийн эрхтэний хоцрогдоор илрэх нь нийтлэг байдаг тул, жижиг, том булчингийн хөдөлгөөнүүдийг шалгана. Мөн хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцаж байгааг хөндлөнгөөс ажиглах нь хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлэхэд тустай.

3.2.2.4 Эрсдэлт хүчин зүйлүүд ба хамгаалагч хүчин зүйлүүдийг олж тогтоох:

Эрсдлийн үнэлгээ бол хүүхдийн хөгжлийг хянахад чухал ач холбогдолтой. Орчны, удамшлын, биологийн, нийгмийн болон хүн ам зүйн гэх мэт олон хүчин зүйл хүүхдийн хөгжлийн хоцрогдолд нэлөөлдөг. Тухайлбал, гэр бүлийн гишүүн архи, тамхи хэрэглэдэг гэх зэрэг хорт зуршилтай байх, эцэг, эхгүй, орлогогүй, хоол хүнсний хомсдолтой, загнаж зодох гэх мэт. Эдгээр эрсдлүүд нь харилцан уялдаж, эрсдлийг улам ихэсгэдэг.

Үзлэгийн явцад эрсдэлт хүчин зүйлүүдийн нэгэн адил хүүхдийн амьдралын хамгаалагч хүчин зүйлүүдийг ч тогтоох шаардлагатай. Тухайлбал: Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, хүүхдүүдийн хоорондын найрсаг харилцаа, чанартай хоол хүнс, зруул орчинд бие дааж өсч бойжих нь хүүхдийн хөгжилд үнэ цэнэтэй юм. Эрсдэлгүй



хүүхдийг 18 ба 36 сартайд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулах ба эрсдэлтэй хүүхдийг даруй хяналтанд авч ойрхон давтамжтай идэвхтэй үзлэгт хамруулна.

3.2.2.5 Үзлэгийн үед илэрч буй шинж тэмдгүүдийг нямбай тэмдэглэж, баримтжуулах ба цуглуулсан мэдээллээ нэгтгэн дүгнэнэ:

Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдаж байгаа бүх хүүхдэд нэгдсэн үзлэгийн маягтыг ашиглана. Маягтыг Эрүүл мэндийн сайд батална. Маягтад хүүхдийн тухайн насанд тохирсон эрүүл мэнд, хөгжлийн гол үзүүлэлтүүдийг тусгасан байна. Үзлэгийн бүхий л үйл ажиллагааг тэмдэглэж баримтжуулах ёстой. Үзлэгийн маягт нь эрүүл мэндийн байгууллагад хадгалагдаж үлдэх ба дараагийн үзлэгт хэдийд ирэхийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж өгнө. Эрүүл мэнд, хөгжлийн аливаа асуудал илэрсэн хүүхдийг илгээх, болон тухайн үед авсан арга хэмжээ зөвлөгөөг заавал тэмдэглэнэ. Хэрэв хүүхдийг нарийвчилсан үнэлгээ, оношилгоонд илгээх шаардлага гарвал тухайн үйлчилгээнд холбож өгнө.

3.2.2.6 Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, БОЭТ зэрэг эрүүл мэндийн байгууллагад оношлуулахаар илгээх ба тэдгээр байгууллага нь шаардлагатай бол хүүхдийг Салбар комисст илгээнэ:

Үзлэгээр эрүүл мэнд, хөгжлийн аль нэг үзүүлэлт асуудалтай байвал мэргэжлийн эмчид илгээх, хөгжлийн үнэлгээ, шинжилгээ болон оношилгоо хийлгэх шаардлагатай. Энэхүү нарийвчилсан үнэлгээгээр тухайн хүүхдэд хөгжлийн хоцрогдол эсвэл эмгэг байгааг илрүүлэн, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ шаардлагатай эсэхийг тогтооно.

Мөн хөгжлийг дэмжих, сэргээн засах үйлчилгээнд хамруулан тодорхой хугацаанд, эцэг эхтэй нь хамтран ажиллаж болно.

БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ХӨВСГӨЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН 18 САРТАЙ
ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ

18 сартай хүүхдийн иж бүрэн үзлэгийг нийслэлийн Баянгол дүүрэгт 2017 оны 05 дугаар сараас, Хөвсгөл аймагт 2017 оны 10 дугаар сараас эхлэн зохион байгуулж, туршиж байна. Ингэхдээ Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (ЭМТ)-ийн захирлын тушаал, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар сар бүрийн 4 дэх долоо хоногт зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Сар бүр зохион байгуулагдаж байгаа үзлэгт орвол зохих нийт 18 сартай хүүхдийн 70-80 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд зуны улиралд хүүхдүүд хөдөө гадаа, зусланд явдагтай холбоотойгоор үзлэгт хамрагдалтын хувь багасах хандлага гарч байв.

Үзлэгийг зохион байгуулахдаа:

1. Цогц үзлэгийн маягтыг бэлтгэх;
2. Өрх, сумын ЭМТ-д ажиллаж байгаа бүх эмч нарыг хүүхдэд үзлэг хэрхэн хийх талаар сургалтад хамруулах;
3. 18 сартай хүүхдийн судалгааг гаргаж үзлэгт урих;
4. Өрх, сумын ЭМТ нь үзлэг хийхэд үзлэгийн маягт, хүүхдийн багцын жин, урт, өндөр хэмжигч зэрэг зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, хөгжлийг үнэлэх тоглоом, зураг, аяга зэргийг бэлтгэсэн байх;
5. Үзлэг хийх өдөр 18 сартай наанадаж 4-5 хүүхдийг нэгэн зэрэг ирүүлэхээр зохицуулах;
6. Үзлэгийн маягтад асуумжийн дэгүү гаргацтай тэмдэглэж, өрх, сумын ЭМТ тус бүр хөгжлөөр хоцрогдох эрсдэлтэй хүүхдүүдийг хяналтанд авч, цаашдын үйлчилгээг эцэг эхтэй нь ярилцаж шийдвэрлэх ба шаардлагатай хүүхдийг төрөлжсөн мэргэжлийн тусlamж үйлчилгээ, оношилгоо, үнэлгээнд илгээнэ.

3.3 ОНОШИЛГОО БА ҮНЭЛГЭЭ

Бүдүүвч 3. Оношилгоо ба үнэлгээ



• Лавлагаа шатлалын (Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, Бүсийн онош, эмчилгээний төв, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ГССҮТ г.м) эрүүл мэндийн байгууллагад төрөлжсөн мэргэшлийн баг оношилгоо дүгнэлт, гаргаж салбар комисс руу илгээнэ.

Гол оролцогчид: Дүүргийн ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, Төрөлжсөн мэргэжлийн баг, ЭХЭМҮТ, СЭМҮТ г.м.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн түвшинд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрдэлтэй хүүхдүүдийг Дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвүүдэд онош тодруулах, үнэлгээ хийлгэхээр илгээнэ.

Оношилгоо гэдэг нь илэрч байгаа шинж тэмдгийг үндэслэн хүний өвчин эмгэгийг илрүүлж, эмчилгээг төлөвлөх үйл явц юм. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад Өвчний олон улсын 10 дугаар ангиалал (ICD-10)-ын дагуу оношилгоо хийдэг. Эмнэл зүйн шинжээр нь хүүхдийн өвчин болон эмгэгийг оношилж, эмчилгээ болон хөгжлийн бэрхшээлийг хэрхэхийг шийднэ. Иймд оношилгоог хөгжлийн үнэлгээний нэг хэсэг гэж ойлгож болно. Мөн эмчийн тавьсан оношийн дүгнэлтийг үндэслэн удаан хугацааны асаргаа шаардлагатай хүүхдүүд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг.

3.3.1 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг оношлох үйл явц

1 дугээр алхам: Төрөлжсөн мэргэжлийн багийг (цаашид “ТМБ” гэх) байгуулах

Хүүхдэд тусламж үзүүлдэг нэгдсэн эмнэлэг, лавлагаа төвүүд нь хүүхдэд цогц үзлэг шинжилгээ хийх зорилгоор хүүхэд, мэдрэл, сэтгэц, чих хамар хоолой, нүд гэх мэт мэргэжлийн эмч нар, сэтгэл зүйч, хөдөлгөөн засалч (РТ), ахуй засалч (ОТ), хэл засалч (СТ), нийгмийн ажилтан зэрэг холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн ТМБ-ийг тухайн эрүүл мэндийн байгууллагын даргын тушаалаар байгуулна.

2 дугаар алхам: ТМБ-ийн зөвлөгөөн

Анх үзлэг хийсэн эмч хүүхдийн хэрэгцээг үндэслэн шаардлагатай тохиолдолд багийн гишүүдээс холбогдох мэргэжилтнийг урьж үнэлгээ хийж оношийн талаар зөвлөгөөн хийнэ. Багаар зөвлөлдсөний эцэст оношийг тогтооно. Тохиолдол бүрт бүх гишүүд цугларах шаардлагагүй. Жишээ нь сонсгалын асуудалтай бол зөвхөн

сонсголын бичлэг хийж дүгнэлт гарган салбар комисс руу илгээж болно. Оношийг Өвчний олон улсын 10 дугаар ангиалал (ICD-10)-ын дагуу тавьж, өвчин эмгэг, чадвар алдалт, сонсголын зэрэг, харааны зэрэг, танин мэдэхүйн хоцрогдол, бие эрхтний хөгжлийг ерөнхийд нь үнэлж, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, эмчилгээг тогтооно.

Хүснэгт 1.

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	
• Эмч нар (хүүхэд, мэдрэл, сэтгэц, чих, хамар, хоолой, нүд г.м.)	
• Сэтгэл зүйч	
• Хөдөлгөөн засалч (PT)	
• Ахуй засалч (OT)	
• Хэл засалч (ST)	
• Нийгмийн ажилтан	
Төрөлжсөн мэргэжлийн багийн зорилго	
• Хүүхдэд мэргэжлийн дагуу шинжилгээ хийх	
• Үзлэгийг үндэслэн тодорхой онош тавих	
• Хүүхэд, гэр бүлд нь зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэх	
• ЭМБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавхийг нэмэгдүүлэх	
Төрөлжсөн мэргэжлийн багийн үйл ажиллагаа	
• Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг үзэж онош тавина.	
• Шаардлагатай бол өрх, сумын ЭМБ –ын ажилтантай уулзаж мэдээлэл авах	
• Хөгжлийн бэрхшээлтний хүүхдийн эх, эцэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх	
• Шаардлагатай бол хүүхдийг дагуулж Салбар комиссын хуралдаанд оруулж мэдээлэл өгнө.	

З дугаар алхам: Эмнэлгийн дүгнэлт гаргаж, цаашдын чиглэлийг тогтооно.

ТМБ нь шаардлагатай хүүхдэд эмнэлгийн дүгнэлт гаргаж, тухайн эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэйгээр Салбар комисст илгээнэ. Салбар комисст илгээх шаардлагагүй зөвхөн сэргээн засалт, эмийн эмчилгээ, шинжилгээ шаардлагатай хүүхдийг холбогдох мэргэжилтэнд илгээж болно.



3.4 ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРУУЛАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

Бүдүүвч 4. Хөгжлийн дэмжлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх



- Салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, 1-халамжийн тэтгэмж олгох, 2 –хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргана. Үүнд: сэргээн засах, боловсролын үйлчилгээ, эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр г.м.

Хариуцах байгууллага: Салбар комисс

Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв болон холбогдох мэргэжилтний онош/дүгнэлт бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аймаг, дүүргийн Салбар комисст илгээнэ.

Салбар комисс нь:

- Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох;
- Нийгмийн халамж, эрүүл мэнд, хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах зөвлөгөө өгч “шийдвэр” гаргах;
- Гаргасан “шийдвэр”-ийн дагуу холбогдох байгууллагуудтай холбон зуучлах үүрэгтэй.

3.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох:

Хөгжлийн бэрхшээлтэй болон удаан хугацааны асаргаа шаардлагатай хүүхдийг эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн онош, үнэлгээ, чадвар алдалтыг үндэслэн шийдвэр гаргана.

Салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон хүүхдийг тохирох хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах төлөвлөгөөг боловсруулж Хүүхдийн хувийн хэрэгт тэмдэглэнэ.

Салбар комисс нь хүүхэд, түүний гэр бүлийг шаардлагатай тусламж үйлчилгээ, байгууллага руу чиглүүлж хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах асуудлыг шийдвэрлэнэ. Шийдвэрийн маягтад хүүхдэд зайлшгүй шаардлагатай хөгжлийн



дэмжлэгийн үйлчилгээний ойрын ба хэтийн зорилт түүнчлэн дэмжлэгийг хариуцан хийх ажилтан /байгууллагыг тусгаж өгнө.

Хүснэгт 2.

ХҮҮХДИЙН БОДИТ БАЙДЛЫГ ТОГТООХОД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛҮҮД	
Зайлшгүй шаардлагатай мэдээллүүд	Эх сурвалж
<u>Ерөнхий мэдээлэл</u> - нэр, нас, ам бүл - эхийн жирэмсэн /терех - хөгжлийн түүх - өвчний түүх - онош - эрүүл мэнд /эмчилгээ	<ul style="list-style-type: none"> Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ЭМБ-аас ирүүлсэн дүгнэлт ба дэмжлэг үзүүлэх чиглэл
<u>Хөгжлийн түвшин</u> - Хөгжлийн ай тус бүрийн үзүүлэлт; нийгэмшил, хэл яриа, бие дааж хийх үйлдэл, танин мэдэхүй, хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> Оношийн дүгнэлт, мэргэжлийн хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө ТМБ-ийн дүгнэлт Эцэг, эх, цэцэрлэгийн багш, хорооны нийгмийн ажилтан
<u>Өвөрмөц шинжүүд</u> - Хүүхдийн өвөрмөц шинж - Таалагдах, эс таалагдах зүйлс, сайн, муу талууд	<ul style="list-style-type: none"> ТМБ-ийн дүгнэлт Эцэг, эх, цэцэрлэгийн багш, хорооны нийгмийн ажилтан
<u>Өдөр тутмын амьдралын хэвшил, ахуй нөхцөл</u> - Өдөр ба долоо хоногийн хуваарь - Найз нөхөд, хүүхдэд таалагддаг болон таалагдаггүй хүмүүс - Гэр бүл нь хүүхдээ анхаардаг байдал	<ul style="list-style-type: none"> Эцэг, эх, цэцэрлэгийн багш, хорооны нийгмийн ажилтан
Нөөц бололцоо: Хүүхэд болон гэр бүл, эцэг, эхийн нөөц боломж. Жишээ нь найз нөхөд, эцэг эх, Эцэг эхийн холбоо г.м.	<ul style="list-style-type: none"> Эцэг, эх, цэцэрлэгийн багш, хорооны нийгмийн ажилтан
- Хүүхдийн хэрэгцээ - Гэр бүлийн хэрэгцээ - Орон нутгийн хэрэгцээ (сургууль нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авах боломжтой эсэх г.м)	

3.4.2 Хүүхэд, түүний гэр бүлийн эрэлт хэрэгцээг судалж мэдэх

Хүүхэд, гэр бүлийн эрэлт хэрэгцээг судалж мэдэх хэрэгтэй. Салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрэлт, хэрэгцээний талаар хүүхэд, түүний эцэг, эхтэй хамтарч ярилцан Хүүхдийн хөгжлийн дэвтэрт тэмдэглэнэ. Эрэлт хэрэгцээ гэдэгт хүүхдийн хөгжил дэх биеийн болон танин мэдэхүйн хэрэгцээ, ТМБ-ийн гаргасан онош, дүгнэлт, эмчилгээ/ дэмжлэгийн төлөвлөгөө орно.

3.4.3 Цуглуулсан мэдээлэлд дүгнэлт хийх

Салбар комисс нь хүүхэд, түүний эцэг, эхтэй уулзахдаа Бүдүүвч 4-т дурдсан мэдээллүүдийн талаар ярилцаж, дүгнэлт хийж, шийдвэр гаргана. Дүгнэлт хийхдээ Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)-ын зарчмыг баримтална.

3.4.4 Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах

Салбар комиссын гишүүд эцэг эхтэй зөвлөлдөн хүүхдийг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах асуудлыг шийдвэрлэнэ. Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөнд чиглэл, зорилго, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хэлбэрүүд болон илгээсэн байгууллага, үйлчилгээ тус бүрийн хариуцах хүнийг тодорхой заана.

Хүснэгт 3.

Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө (Жишээ)			
Хүүхдийн нэр : Ц Нас:	Огноо:	Хариуцах хүн:	
Зорилт:			
Хэтийн (1 жил)	Цэцэрлэгт оруулах		
Ойрын (3 сар)	Долоо хоногт 1 удаа цэцэрлэгт явах		
Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө:			
Төрлүүд	Илгээх байгууллагын нэр	Зорилт	Хариуцах хүн
Бие махбодын бүтэц, үйл ажиллагаа	<input type="checkbox"/> Өрхийн ЭМТ <input type="checkbox"/> Дүүргийн ЭМТ ба НЭ		
	<input type="checkbox"/> Лавлагаа төв ¹⁴		
	<input type="checkbox"/> Бусад		

¹⁴ Төрөлжсөн мэргэжлийн тусlamж үзүүлдэг ЭМБ

Үйл ажиллагаа /үйлчилгээ/	<input type="checkbox"/> Хүүхдийн хөгжлийн төв <input type="checkbox"/> Сэргээн засах үйлчилгээ <input type="checkbox"/> Портеж хөтөлбөр <input type="checkbox"/> Хамт олонд суурилсан сэргээн засалт		
Оролцоо	(Боловсрол) <input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> Эх хүүхдийн хөтөлбөр <input type="checkbox"/> Сургууль <input type="checkbox"/> ТББ <input type="checkbox"/> Бусад		
	Олон нийт		
Орчин	(Нийгмийн хамгаалал) <input type="checkbox"/> Асаргааны тэтгэмж <input type="checkbox"/> Хиймэл эрхтэн <input type="checkbox"/> Бусад		
Бусад	Цэцэрлэгүүд хүүхдийг хүлээн авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авах талаар цэцэрлэгүүдтэй ажиллахыг тусгай сургуулийн багш нараас хүсэх/.		

Давтан үзлэг, хяналтыг 3 сарын дараа хийнэ.


3.4.5 "Үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилал" (ICF)-ыг ашиглан хүүхдийн хөгжлийг үнэлж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах

Хөгжлийн үнэлгээг хийх, хөгжлийн дэмжлэгт хамруулах төлөвлөгөөг боловсруулах явцад "Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал" (цаашид "ICF" гэх)-ыг ашигласнаар хүүхдийг бүхий л талаас нь дүгнэх боломж бүрддэг. Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын Хүүхэд залуучуудын хувилбар¹⁵-ын үндсэн зарчим нь хөгжлийн бэрхшээлийг зөвхөн биологийн эсвэл нийгмийн талаас нь харах хандлагаас

¹⁵ Англи: International Classification of Functioning, Disability and Health: Children and Youth Version буюу ICF-CY

татгалзаж, харин эрүүл мэндийн байдал, хүний амьдарч буй орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл хэмээн үздэг байна. Энэхүү ангилал нь стандарт хэллэг бөгөөд хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нөхцөл байдлуудыг бүхэлд нь авч үздэгээрээ олон салбарын мэргэжилтнүүд хамтарч шийдвэр гаргах үр дүнтэй хэрэгсэл болдог.


Бүдүүвч 5. Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын өрөнхий зарчим (ICF)



ICF-ИЙГ БҮРДҮҮЛЭГЧ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД		
ICF-ийн хүчин зүйл	Тодорхойлолт	Жишээ
Сэтгэл санаа, бие махбодын үйл ажиллагаа	Биеийн эрхтэн системийн физиологийн үйл ажиллагаа (Сэтгэл зүйн үйл ажиллагааг багтаана)	Оюун ухаан, сэтгэл хөдлөл, хараа, сонсгал, булчингийн чадал г.м.
Биеийн бүтэц	Эрхтэн, тулгуур эрхтэн ба түүнийг бүрдүүлэгч хэсэг г.м. биеийн эрхтэн системийн анатоми	Тархи, нурууны нугас, дээд болон доод мөч, дотор эрхтэн г.м.
Үйл ажиллагаа	Хувь хүн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, үйлдэл гүйцэтгэх байдал	Харилцаа, хөдөлгөөн, өөртөө тавих анхаарал халамж, гэрийн ажил г.м.
Оролцоо	Амьдрал, амьдралын үе, уялдаа холбоо	Ар гэрийн амьдрал, боловсрол, ажил эрхлэлт г.м.
Хүрээлэн буй орчны хүчин зүйл	Хүмүүсийн амьдарч, аж төрөн буй материаллаг болон нийгмийн орчин, хүмүүсийн нийгмийн хандлагын орчныг бүрдүүлдэг хүчин зүйлүүд	Халамжийн хэрэгсэл, хүмүүсийн харилцаа, хандлага, олон нийтийн үйлчилгээ, тогтолцоо, хууль г.м.
Хувь хүний хүчин зүйл		Боловсрол, нийгмийн шалтгаан, амьдралын хэв маяг

3.5 ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Бүдүүвч 6. Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ



Байгууллагууд: Салбар комисс, Эрүүл мэндийн байгууллага, СӨБ, ЕБС, ТББ, Хамт олонд сууринсан сэргээн засалт, Эх, хүүхдийн хөгжлийн хөтөлбөр г.м.

Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах үйл явц

Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг 1) Суурь үйлчилгээ, 2) Зорилтот үйлчилгээ гэж ангилж болно.

3.5.1 Суурь үйлчилгээ

- Эрүүл мэндийн үйлчилгээ, сургуулийн өмнөх болон бага боловсрол, нийгмийн үйлчилгээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл ёсч бойжих нь нэн чухал тул тэднийг эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээнд хамруулах боломжоор хангах шаардлагатай.
- Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ) болон бага боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан идэвхтэй сурч боловсрох, тохирох хэрэглэгдэхүүн, болон орчин бүрдүүлэх шаардлагатай бөгөөд суралцах, тоглох, аливаа үйл ажиллагаанд оролцох, үе тэнгийнхэнтэйгээ харилцах, үерхэж нөхөрлөх боломжоор хангаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжих хамгийн сайн нөхцөл боломж бүрдэнэ.

3.5.2 Зорилтот үйлчилгээ

- Эмчилгээ, сэргээн засалтын үйлчилгээ

Энд “Байгууллагад сууринсан үйлчилгээ” ба “Гэр бүлийг дэмжих үйлчилгээ” багтана.

- Байгууллагад сууринсан үйлчилгээ

Байгууллагад сууринсан үйлчилгээ нь Хүүхэд хөгжлийн төв, эсвэл Эрүүл мэндийн төв, эмнэлэгт үзүүлдэг. Портеж эрт боловсролын хөтөлбөрийг байгууллагад сууринсан болон гэр бүлд сууринсан үйлчилгээний аль ч хэлбэрээр зохион байгуулах

боломжтой. (Портеж эрт боловсролын хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 6-аас үзнэ үү).

Жишээ: Хөдөлгөөн засал, ахуй засал, протез ортопедийн хэрэгсэл, хэл засал, хараа болон сонсголын бэрхшээлийн тусгай эмчилгээ засал.

- Гэр бүлийг дэмжих үйлчилгээ

Гэр бүлийг дэмжих үйлчилгээ нь янз бүрийн нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийн хэрэгцээг ойлгох, эрхийг нь хангах, дэмжлэг үзүүлэх мэдлэг, чадварыг гэр бүлд нь олгоход чиглэгдэнэ.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн явц байдлын талаарх мэдээлэл, тэдэнд шаардлагатай арга хэмжээ, дэмжлэг, үйлчилгээ болон эмчилгээнд нь хэрэгтэй нөөц бололцооны талаарх мэдээллийг цуглуулна.

3.5.3 Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх үйл явц

1 дүгээр алхам: Салбар комиссын гаргасан шийдвэрийн дагуу хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх;

Салбар комисс дүгнэлт гаргаж, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг хүүхдийн гэр бүлд танилцуулах ба тус байгууллага (сургууль, цэцэрлэг гэх мэт боловсролын байгууллага, сэргээн засалт, сувилал, эх, хүүхдийн хөтөлбөр г.м) нь Салбар комиссын шийдвэрийн дагуу тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлнэ. Ингэхдээ байгууллага бүр тухайн хүүхдэд Салбар комиссын дүгнэлтийн дагуу тодорхой зорилгод хүрч биелэгдэх боломжтой агуулга, аргачлалыг нарийвчлан тусгасан хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулна.

2 дугаар алхам: Тэмдэглэл хөтлөх;

Тухайн хүүхдэд ямар үйлчилгээ үзүүлсэн болох, хүүхдийн нөхцөл байдал ямар байгаа талаар эцэг, эх, үйлчилгээ үзүүлэгч аль аль нь тэмдэглэл хөтөлнө.

3 дугаар алхам: Хөгжлийн дэмжлэгийн явцыг хянах;

- Салбар комисс нь тухайн илгээсэн хүүхэд болон түүний асран хамгаалагчийг тодорхой хугацаанд (давтамж нь тухайн хүүхдийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр байж болно) ээлжит хуралдаанд урин оролцуулж, хөгжлийн дэмжлэгийн явцыг тодруулна. Салбар комиссын дүгнэлт, шийдвэрийн дагуу хүүхдэд тохигох дэмжлэг үзүүлсэн эсэхийг шалгана. Хэрэв тохигох дэмжлэг үзүүлээгүй



бол Салбар комиссын зүгээс тодорхой арга хэмжээ авна. Тухайлбал, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай уулzan зөвлөгөө өгөх гэх мэт.

- Салбар комиссын хуралдаанаар шийдвэрлэхэд төвөгтэй тохиолдол гарвал Салбар комиссын зүгээс “Кэйс хэлэлцүүлэг” зохион байгуулж, тухайн хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулна. Кэйс хэлэлцүүлэг гэдэг нь тухайн хүүхдийг дэмжих (энэхүү зааварт хүүхдэд үзүүлэх дэмжлэг), цаашдын төлөвлөгөөг сайтар боловсруулах зорилгоор олон салбарын мэргэжилтнүүд хамтарч тухайн тохиолдлыг олон талаас нь хэлэлцэж зөвлөлддөг хурал юм. Үүнд Салбар комисс чухал үүрэгтэй бөгөөд Салбар комиссын гишүүд, эмнэлэг, хүүхэд хөгжлийн төв, цэцэрлэг, ТББ зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан кэйс хэлэлцүүлэг зохион байгуулна. Кэйс хэлэлцүүлэгт ICF-ын ерөнхий зарчмуудыг баримтлах нь тохиромжтой.

3.5.4 Кэйс хэлэлцүүлэг, кэйс сонгох

Салбар комисс хяналт үнэлгээ хийх явцад, хөгжлийн дэмжлэг үр дүнгүй эсвэл нэмэлт дэмжлэг шаардлагатай гэж үзсэн хүүхдийг сонгож, кэйс хэлэлцүүлэгт оруулна.

Хүснэгт 5.

Кэйс хэлэлцүүлэг

Кэйс хэлэлцүүлгийн зорилго нь:

- 1) Тухайн хүүхдэд тулгамдсан нөхцөл байдал, асуудалд дүн шинжилгээ хийх;
- 2) Холбогдох байгууллагын тухайн хүүхдэд дэмжлэг үзүүлэх мэргэжил арга зүйн, болон нөөцийн талаарх мэдээллийг танилцуулах;
- 3) Хүүхдийг дэмжих хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан, дэмжлэг үзүүлэх үйл явцад оролцох байгууллага болон хүн бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж зөвшилцнө.

Жишээ:


Бэлтгэл ажил:

1. Кэйс хэлэлцүүлэгт оролцуулах холбогдох байгууллага, хүнийг сонгох;
2. Оролцогчдоос тухайн кэйсийн талаар мэдээлэл бэлтгэж ирэхийг хүсэх;

Кэйс хэлэлцүүлэг:

1. Оролцогчдыг танилцуулах;
2. Оролцогч бүр өөрсдийн хэлэлцүүлэх кэйсийн талаарх мэдээллийг (одоо хүртэлх түүх, ямар үйлчилгээ үзүүлсэн, тулгамдсан асуудал г.м.) танилцуулах;
3. Тулгамдсан асуудлыг тодорхой болгож, байгаа нөөц боломжуудыг тооцсоны үндсэн дээр шийдвэрлэх гарцыг зөвшилцнө;
4. Цаашдын төлөвлөгөөг боловсруулан, хэрхэн хэрэгжүүлэх, хариуцан ажиллах байгууллага, хүнийг хамтран тохирно.

Бүдүүвч 7. Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах үйл явц



Хүснэгт 6.

“ПОРТЕЖ” ЭРТ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

Портеж хөтөлбөр нь 1972 онд АНУ-ын Вискинсон мужийн Портеж хотод боловсруулсан. Хотын ихэнх хүн ам нь төвөөс алслагдмал, тархмал суурьшилтай байснаас дэмжлэг шаардлагатай тухайн хүүхдийн гэрт нь очиж зөвлөгөө өгч эхэлжээ. Өнөөдөр дэлхийн 35 гаруй орон уг хөтөлбөрийг өөрсдийн хэлэнд хөрвүүлэн ашиглаж байна.



“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” нь Японы 20 гаруй жилийн эмнэл зүйн туршлага, судалгааны үр дүнд бий болсон “Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн Монгол хувилбарыг боловсруулж байна. Энэ зорилгоор 2016 оны 9 дүгээр сараас эхлэн “Монголын Аутизмын Холбоо” ТББ болон “Монголын Дауны Холбоо” ТББ-тай хамтран Портеж хөтөлбөрийг туршсан юм.

Энэхүү хөтөлбөр нь, хүүхдийн хөгжлийн төлөв байдлыг судлах зорилготой шалгах хуудас (Нялхсын хөгжил, нийгэмшихүй, хэл яриа, бие дааж хийх үйлдэл,

танин мэдэхүй, хөдөлгөөн зэрэг хөгжлийн 6 ай, 576 даалгавар), хүүхдийг хөгжүүлэх даалгаврын карт, даалгавар гүйцэтгүүлэх заавар, хөгжлийн явцыг тэмдэглэх хүснэгт зэргээс бүрддэг.

Хөтөлбөрийн онцлог:

Тус хөтөлбөр нь дараах гурван онцлогийг агуулж байдаг.

(1) Эцэг эх, гэр бүл нь зорилтот хүүхдийг гэртээ даалгавар ажиллуулах замаар тасралтгүй хөгжүүлэх боломжтой. Хүүхдээ хөгжүүлэхэд нь зориулалтын байр, тусгай хэрэгсэл шаардагдахгүй.

(2) Хүүхдийн хэвийн хөгжлийн үе шат, явцтай зорилтот хүүхдийн байдлыг харьцуулах замаар хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах боломжтой.

(3) Хүүхдийн гаргаж буй зан үйл, үйлдэлд үнэлгээ хийн дүгнэлт гаргах явцдаа дараагийн даалгавруудыг сонгож, үр дүнг нь тухай бүр тэмдэглэж авах боломжтой.

Хөгжлийн үнэлгээ → Даалгавар сонгох → Даалгаврыг гүйцэтгүүлэх төлөвлөгөө боловсруулах → Гэрт даалгавар ажиллуулах → Үр дүнг шалгах гэсэн тасралтгүй үе шатаар явагддаг.

Портеж хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн хүүхдийн бэрхшээлийн онцлог, хөгжлийн явцын талаар мэдээлэл цуглуулах нь чухал. Мөн оюун ухааны жишиг тестиийн үр дүнг харгалзан үзэх, хүүхдийн гаргадаг зан үйл, үйлдэлд ажиглалт хийнэ. Түүнчлэн шалгах хуудас ашиглан уг хүүхдийн анхаарал татсан асуудлыг мэдэх боломжтой. Шалгах хуудсаар тодорхой болсон асуудлыг (Жишээ: Өмдөө ганцаараа тайлж чадахгүй) шийдвэрлэхийн тулд үйлийн зорилтоо (Жишээ: Хүүхэд "A" 2 удаагийн 2-т нь өмдөө тайлна) тодорхойлох бөгөөд дүн шинжилгээний заавар ашиглан даалгавраа хэд хэдэн алхмуудад (Жишээ: Алхам 1. Өмдөө шагай хүртэл доошлуулахад нь туслах. Алхам 2. Өмдөө өвдөг хүртэл доошлуулахад нь туслах. Алхам 3. Өмдөө өгзөг хүртэл доошлуулахад нь туслах. Алхам 4. ... г.м.) хуваан гүйцэтгэх төлөвлөгөө гаргана.

Харин гэр булийн бүх гишүүн уг төлөвлөгөөний дагуу хүүхдээр даалгавар гүйцэтгүүлнэ. Мэргэжилтэн тодорхой хугацааны дараа тухайн хүүхэд болон түүний гэр булийнхэнтэй уулзаж, даалгавар гүйцэтгэлийн үр дүнг шалган бататгахын зэрэгцээ шаардлагатай бол нэмэлт зөвлөгөө өгнө.



Нийтийн зорилтууд	Нийтийн зорилтууд	Нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд
Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд	Хүүхэдийн нийтийн зорилтууд


3.6 БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага нь хөгжлийн бэрхшээл, ядуурал, хүйсийн ялгаа, яс үндэс, шашин шүтлэг зэргээс шалтгаалан нийгмийн үйлчилгээний гадна үлдэж болзошгүй хүүхдүүдийг бусад хүүхдийн адил чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалсан “Тэгш хамруулан сургах” тогтолцоонд чиглэж байна.


Тэгш хамруулан сургах нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд хамруулахаад зогсох биш, тухайн сургууль нь хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нь нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж сурх орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасанчлан Монгол улс дахь боловсролын аливаа байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүрэгтэй юм.

3.6.1 Тэгш хамруулан сургах ба тохирох хэрэглэгдэхүүн

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд бусад хүүхдүүдийн адилгаар сурч боловсрон өдөр тутмын амьдралд оролцох бололцоог олгоходоо сургуульд хэт ачаалал дарамт үүсгэхгүйгээр тохируулга, өөрчлөлтийг хийж сурх орчин нөхцөлийг бүрдүүлж доорх алхмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хүлээн авахад чиглэсэн бэлтгэлийг ханган, тохируулга хийх шаардлагатай.



Бүдүүч 8: Хөгжлийн хохирогдол бэрхшээлүүдийг одоогийн хөгжлийн талбай наасаад олон нийтийн хөгжлийн талбайг зурсахад хувь нийтлэж болно.



2012.06.08, "Түсийн хөгжлийн бодлогоор подложишинаар түсийн хөгжлийн талбайн санчурлагыг чинжилж болно.

3.6.2 Тэгш хамруулан сургах орчин бүрдүүлэх

3.6.2.1 Барилга байгууламжийн саадыг арилгах

Шинээр барилга барих, хуучин барилга байгууламжийг засварлахдаа, хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцан сургуулийн өдөр тутмын амьдралд оролцоход нь хүндрэл бэрхшээл учруулахуйц материаллаг саад тогторыг арилгах, багасгах зорилт тавих хэрэгтэй.

Зураг1. Барилга байгууламжийг тохируулга хийж саадгүй болгосон жишээ

Налуу зам тавьж өгсөн. (186 дугаар цэцэрлэг)	Бие засах өрөөнд бариул суурилуулж, хангалттай зйтай тохижуулсан. ("Шинэ эрин" лаборатори сургууль)	Гоожуурыг биеийн өндөр намдаа тохируулан сонгож хэрэглэх боломжтой болгожээ. (28 дугаар сургууль)

3.6.2.2 "Нийтлэг загвар"-ыг хичээлд ашиглах

"Нийтлэг загвар"¹⁶ гэдгийг хүн бүр ашиглах боломжтой хэв маягаар төлөвлөсөн загвар гэж тодорхойлсон байдаг.

Хүснэгт 7.

НИЙТЛЭГ ЗАГВАРЫН 7 ЗАРЧИМ
<ol style="list-style-type: none">1) Бүх хүн ашиглах боломжтой байх (Адил тэгш)2) Хэрэглэхэд тохиромжтой байх (Уян хатан)3) Хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байх (Энгийн, ойлгомжтой)4) Шаардлагатай мэдээллийг шууд ойлгох боломжтой байх (Танин мэдэх боломжтой мэдээлэл)5) Санамсаргүй алдаа осолд тэсвэртэй, бат бөх байх (Алдаа осолд тэсвэртэй)

¹⁶ АНУ-ын Хойд Каролина мужийн их сургуулийн профессор Рональд Л.Мейсийн 1985 онд дэвшүүлсэн үзэл баримтлал

- 6) Биеэс хэт хүч гаргахааргүй байх. (Бага хүч шаардагдах)
 7) Хүртээмжтэй, орон зайны хувьд хангалттай байх. (Ашиглахад хангалттай хэмжээ, зайд талбай)

Нийтлэг загварын эдгээр 7 зарчмыг ашигласнаар, хөгжлийн бэрхшээлтэй болон суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд төдийгүй бусад хүүхдэд ч хүртээмжтэй хичээл зохион байгуулах боломжтой болно.

Зураг 2. Нийтлэг загварыг хичээлд ашиглах жишээ

	Хаана, юу тавих вэ гэдгийг харахад ойлгогдохоор болгосон (Гадуур хувцас тавих тавиурт гадуур хувцасны зураг, өмд тавих тавиурт өмдний зураг наасан). (186 дугаар цэцэрлэг)
	Самбар төлөвлөлтийн тухайд, хичээлийн үйл явцыг картаар үзүүлэх, өнгийн шохой ашиглах, зураг ашигладаг. Багш нар нь хичээл зохион байгуулах, самбар төлөвлөхдөө тогтсон нэг арга ашиглавал хүүхдүүдийн хувьд таамаглахад хялбар байдаг.
<p>“Сайн сонсоорой” ГЭХИЙН ОРОНД “Ярьж байгаа хүнийхээ царай руу харж байгаад сонсоорой” ГЭХ. “Түргэхэн бэлтгээрэй” ГЭХИЙГ “... минутад бэлтгээрэй” ГЭЖ ХЭЛЭХ.</p>	<p>“Сайн”, “Түргэн” гэж хэлэхэд, ямар үед “Сайн” байх, хэр “Түргэн” бэлтгэх ёстой вэ гэдгийг ойлгохгүй хүүхдүүд гардаг. Тодорхой тогтсон үгээр хэлж өгснөөр хүүхдүүд илүү сайн ойлгодог болно.</p>

3.6.2.3 Олон талт байдлыг харилцан хүлээн зөвшөөрдөг анги сургуулийг бий болгох

Юуны өмнө багш ажилтнуудын болон сурагчдын хоорондын ялгаатай байдлыг харилцан хүлээн зөвшөөрч, нэгэндээ тусалдаг анги сургууль, хамт олныг бий болгох нь хамгаас чухал. Сурагчид алдаж будилах, эсвэл сайн ойлгохгүй байх үед загнаж

Үгүйсгэхгүй, хүүхэд бүр айж эмээх зүйлгүй, тайван, идэвх, сонирхолтой суралцахуйц орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

3.7 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД ЭЛСҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх үйл явц нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- 1) "Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийг сум, хороонд байгуулан, элсэхийг хүссэн хүүхдийн хэрэгцээг тодруулах;
- 2) Сургууль дотор дэмжлэгийн багийг байгуулах;
- 3) Хүүхдийн хэрэгцээнд нь нийцсэн тохиорох хэрэглэгдэхүүнээр хангах, үр дүнд хяналт үнэлгээ хийх ;
- 4) Бусад сурагчид, тэдний эцэг эхийн ойлголт, оролцоог дээшлүүлэх.

3.7.1 Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулан, элсэх хүүхдийн хэрэгцээг тогтоох

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд:

- Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газрын хариуцсан мэргэжилтэн
- Салбар комиссын боловсрол хариуцсан мэргэжилтэн
- Тухайн хүүхдийн суралцах сургуулийн захирал
- Сургалтын менежер
- Нийгмийн ажилтан
- Сургуулийн эмч
- Хүүхдийн асран хамгаалагч орж болно.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь хүүхдийн, ар гэрийн амьдрал, суралцахад нь шаардлагатай тохиорох хэрэглэгдэхүүн, шийдвэрлэх боломжтой хугацаа, хэн хариуцах зэрэг асуудлуудыг хэлэлцэнэ. Мөн хичээлээс гадуур шаардлагатай бусад дэмжлэг (эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалт г.м.)-ийн талаар тодруулан Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн тэмдэглэлийн маягтад тэмдэглэж, ямар сургуульд элсүүлэх, б нас хэтэрсэн тохиолдолд хэддүгээр ангид оруулах зэрэг асуудлыг шийдвэрлэнэ. Сургуулийн зүгээс хичээлийн байрныхаа орчин



нөхцөл тохиромжгүйгээр шалтаглан хүүхэд авахаас татгалзаж болохгүй. Нөгөөтэйгүүр тохирох хэрэглэгдэхүүнээр хангах тал буюу сургуульд хэт ачаалал, дарамт үүсгэхгүй байдлаар хэрэгжүүлэх боломжтой арга замыг эрэлхийлэх шаардлагатай.

Салбар комиссын шийдвэрийн маягтыг (Хавсралт 2) үндэслэн тухайн хүүхдийн "Хувийн хэрэг", өмнө нь хамрагдаж байсан (хэрэв боловсролын ямар нэгэн байгууллагад хамрагдаж байсан бол) боловсролын байгууллагын шилжүүлэх бичиг зэргийг хүүхдийн асран хамгаалагч нь авч ирнэ.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хуралд оролцогчид нь тухайн хүүхдийн бодит байдлыг судлахын зэрэгцээ хүүхэд, түүний асран хамгаалагчийн хүсэлтийг судалж үзнэ.

3.7.2 Сургууль дотор дэмжлэгийн багийг байгуулах

Тухайн хүүхдийг хүлээж авсан сургууль нь өөртөө "Дэмжлэгийн баг" байгуулна. Дэмжлэгийн багийн бүрэлдэхүүнд:

- Сургуулийн удирдлага
- Нийгмийн ажилтан
- Сургуулийн эмч
- Анги удирдсан багш
- Бусад хичээл заах багш орно.

Дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө" боловсруулахаас гадна хүүхдийн өвермөц хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн байгаа эсэхэд хяналт тавина. Тус баг нь улиралд нэг удаа хуралдаж, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг засаж сайжруулах болон цаашдын чиглэлийг хэлэлцэх ба үр дүнг Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газарт тайлagnана. Сургууль өөрийн дотоод нөөц бололцоогоор шийдвэрлэх боломжгүй тохиолдолд боловсролын байгууллага, эрүүл мэнд, халамжийн мэргэжилтэн, орон нутгийн нийгэм хамт олонтой хамtran ажиллаж шийдвэрлэнэ.



3.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохиорох хэрэглэгдэхүүнээр хангах, үр дүнд хяналт үнэлгээ хийх

Сургууль нь сурагчдынхаа өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохиорох хэрэглэгдэхүүнээр хангана. Жишээ:

Харааны бэрхшээлтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэгдэхүүний жишээ:

Харааны бэрхшээлийн хувьд, сайн хардаггүй (нарийн жижиг хэсгүүдийг сайн хардаггүй, харах талбай багатай гэх мэт), огт хардаггүй зэргээр хүүхэд бүрт харилцан адилгүй байдаг. Хөдөлгөөн ихтэй авто зам, анх удаа явж байгаа газарт зорчиход хүндрэл бэрхшээл тулгарна.

- Тухайн сургач брайль үсэг уншиж сурсан бол сурах бичиг, сургалтын материалыг нь брайль үсэгтэй болгоно. Үсэг нь том байх тусам сайн уншдаг бол үсгийг нь томоор бичсэн сургалтын материал ашиглана.
- Хичээлийн явцад, багш нь “Энэ”, “Тэр”, “Иймэрхүү” гэх мэт заах төлөөний үг ашиглалгүй, тодорхой нэр ашиглан ярина. Мөн самбарт бичсэн зүйлийг уншиж өгнө.
- Шалгалтын үед тухайн сурагчийн нөхцөл байдалд тохируулан брайль үсэг, томруулсан үсэг ашиглах, эсвэл уншиж өгөх, аудио төхөөрөмж ашиглана.
- Суралцах явцад хүүхэд тухайн бодит зүйл, эсвэл үзүүлэнд гар хүрэх, барьж үзэх боломжийг аль болох нэмэгдүүлнэ.
- Сайн хардаггүй бол нэмэлт гэрэлтүүлэг ашиглах, эсвэл суудлын байрлалыг нь өөрчлөх зэргээр анхаарал тавина.
- Сургуулийн дотоод үйл ажиллагаанд оролцоход нь хялбар болгохын тулд эд зүйлсийг ойлгомжтой байрлуулах, явахад хялбар байлгах үүднээс босго довжоог тэгшлэх, эсвэл хөтөч хавтанцар байрлуулах, анги танхим, өрөөнүүдийн нэр дугаарыг брайль үсгээр бичих, шат гишгүүр коридорыг тод өнгөөр будах зэрэг арга хэмжээ авна.

Сонсголын бэрхшээлтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэгдэхүүний жишээ:

Сонсголын бэрхшээлийн хувьд сайн сонсдоггүй, огт сонсдоггүй зэргээр хүүхэд бүрт харилцан адилгүй байдаг. Өнгөц харахад бэрхшээлтэй гэдэг нь төдийлөн



мэдэгдэхгүй тул хүмүүс бараг анзаарагүй байж болно. "Хүн юм асуугаад байхад үл тоолоо" гэж эндүүрэх хүн ч гарна.

- Тухайн сурагч дохионы хэл сурсан бол дохионы хэлний орчуулагч, эсвэл тэмдэглэл хөтлөгч¹⁷ ажиллуулна.
- Хичээлийн явцад, багш нь амны хөдөлгөөнөө тухайн сурагчид харагдахаар ярина.
- Хэлж тайлбарлах зүйлээ тухайн сурагчид цаасан дээр урьдчилан бичиж өгнө.
- Тухайн сурагч сайн сонсохгүй гэдгийг ангийн бусад сурагчдад тайлбарлаж өгөх зэрэгээр сурагчдын сайн харьцааг нь дэмжинэ.
- Сонсоход хялбар, багшийн амны хөдөлгөөнийг харахад нь хялбар байхыг бодолцсон тухайн сурагчийн судллын байрлалыг нь тогтооно.

Бие эрхтний бэрхшээлтэй сурагчид зориулсан тохирох хэрэглэгдэхүүний жишээ:



Бие эрхтний бэрхшээлтэй сурагчид тулгардаг хүндрэл: Алхаж гишгэх, шатаар өгсөж уруудах, сандалд суух, ширээн дээр байгаа зүйлийг авах, хуулж бичих, хооллох зэрэг өдөр тутмын амьдрал, суралцахуйн бүх үйлдэл хөдөлгөөнд, эсвэл заримд нь хүндрэл тулгарна.

- Үйлдэл хөдөлгөөнд бусдаас илүү цаг зарцуулдаг (Бичих, хувцас солих г.м.) учир цагийн зохицуулалт хийж өгнө.
- Гараар бичихэд хүндрэлтэй байвал, компьютер ашиглаж болно.
- Лифт болон налуу зам тавих, эсвэл шат болон коридорын хананд бариул хийж өгнө.

¹⁷ Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, суралцагчийн хичээлийн агуулгыг түүний оронд товчлон тэмдэглэж өгдөг хүн. Японы их дээд сургуулиуд оюутан сайн дурынхныг элсүүлэн томилж ажиллуулдаг.



Зураг 3. Бие эрхтний бэрхшээлтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэгдэхүүний жишээ

		
Тэргэнцэртэй хүүхэд орж гарах боломжтой байлгахын тулд ангийнхаа хаалганы босгыг налуу болгожээ. (63 дугаар тусгай сургууль)	Хичээлд оролцоход хялбар болгох үүднээс жижиг самбар тавьж өгсөн. (63 дугаар тусгай сургууль)	Саажилттай хүүхэд ч барихад тохиromжтой аяга ашигладаг.

Оюуны бэрхшээлтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэгдэхүүний жишээ:

Оюуны бэрхшээлтэй сурагчид тулгардаг хүндрэл: Суралцахуйгаар олж авсан мэдлэг, ур чадвар нь амархан мартагддаг, эсвэл амьдрал дээр бодитоор ашиглаж чаддаггүй. Мөн амжилттай сурсан зүйл цөөн зэргээсээ шалтгаалан өөртөө итгэх, санаачлагаараа хийж сурахад хүндрэлтэй.

- Ахуй амьдралд хэрэгтэй арга технологи, биеэ авч явах байдалд сургахын зэрэгцээ нийгмийн амьдралын хэв маяг, дүрэм журмыг ойлгуулахад чиглэсэн хичээл зохион байгуулна.
- Оюуны хөгжилд нь тааруулан, суралцах агуулгад нь өөрчлөлт, тохируулга хийнэ.
- Хараад ойлгоход нь туслах үүднээс бодит зүйл болон фото зураг, хуваарь зэргийг ашиглана.
- Өөрийгөө хулээн зөвшөөрөх мэдрэмжийг нь дээшлүүлэхэд чиглэсэн хичээл зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

Зураг 4. Оюуны бэрхшээлтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэдэхүүний жишээ


		
Хичээлийн хуваарийг нь ойлгомжтой болгосон. (130 дугаар тусгай сургууль)	Зурагтай карт, үсгийн карт ашигладаг.	Талх барих дарааллыг фото зургаар үзүүлсэн. (25 дугаар тусгай сургууль)

Аутизмын хүрээний эмгэгтэй сурагчид зориулсан тохиорох хэрэглэдэхүүний жишээ:

Аутизмтай сурагчид тулгардаг хүндрэл: Бусад хүнтэй харилцахад хүндрэл үүсэх, хэл ярианы хөгжилд нь илт хоцрогдол илрэх, ярьсан зүйлийг өөр утгаар ойлгох, зан үйлийн алхам дараалал болон аргад нь онцгой шинж илрэх тохиолдол гардаг.

- Суралцах явцдаа “Хэзээ”, “Хаана”, “Юуг”, “Хэрхэн” хийж гүйцэтгэх ёстойг нь ойлгомжтой, нүдэнд нь харагдахуйцаар үзүүлнэ.
- Аль болох бодит туршлага хуримтлуулах боломжоор хангана.
- Урлаж бухимдсан үед нь тайвшруулах боломжтой орон зайг бий болгож өгнө.

Зураг 5. Аутизмтай сурагчид зориулсан тохиорох хэрэглэдэхүүний жишээ

		
Мэдээллүүдийг хараад ойлгохоор үзүүлсэн. (70 дугаар тусгай сургууль)	Тавиур доторх зүйлс нүдэнд нь харагдахад анхаарал нь сарниад байдаг тул хөшиг хийж өгсөн. (63 дугаар тусгай сургууль)	Дуу чимээнд хэт эмзэг тул сандал, ширээ нааш, цааш нь чирэх чимээ сонсогдохгүй байх аргыг бодож олжээ. (Японы сургуулийн жишээ)

3.7.4 Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

Ердийн сургалтын хөтөлбөрт нийцэхгүй сурагчид Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан сургадаг. Дээр өгүүлсэн “Дэмжлэгийн баг”, хүүхдийн асран хамгаалагч зэрэг холбогдох хүмүүс хамtran Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулснаар тухайн хүүхдийн хэрэгцээг зөв тодорхойлж, урт хугацаанд дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ. Боловсруулах аргачлалыг “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал¹⁸”-аас үзэж болно.

3.7.5 Бусад сурагчид, тэдний эцэг эх, гэр бүлийнхний оролцоог дээшлүүлэх

Тэгш хамруулан сургах боловсролыг бодит ажил болгоход, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулаад орхих бус, сургууль нь тухайн хүүхдүүдийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөгдхөн шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгардаг саад бэрхшээлийг зөв ойлгон хүлээн авч, хүүхэд бүрийн өвөрмөц байдалд тохирсон харилцааг бүрдүүлэхийн тулд, сургуулийн зүгээс зөвхөн багш, ажилтнууд төдийгүй, бусад хүүхдүүд, сурагчид болон тэдний эцэг эх, гэр бүлд идэвхтэй нөлөөлөн, тэдний оролцоог нь нэмэгдүүлэх нь чухал юм.

Хүснэгт 8.

130 ДУГААР СУРГУУЛИЙН ЖИШЭЭ

“Монголын Дауны Холбоо” ТББ нь Нийслэлийн 130-р сургуульд тусгай анги нээн ажиллуулж даунтай 10 хүүхдийг сургаж байна.

Дауны хам шинжтэй хүүхдүүд тусгай анgid хичээллэдэг боловч биеийн тамир, дуу хөгжмийн хичээлийг ердийн ангийн хүүхэдтэй хамт ордог. Баяр ёспол, биеийн тамирын тэмцээн, урлагийн үзлэг зэрэг олон нийтийн ажилд бусад хүүхэдтэй хамtran оролцох болсноор ердийн ангийн хүүхдүүдийн хандлагад эерэг өөрчлөлт ажиглагдаж байна.

Сургуулийн зүгээс зохион байгуулсан асран хамгаалагчдын уурзалтаар Дауны холбооны зүгээс дауны хам шинж болон тэгш хамруулан боловсролын тухай танилцуулга хийснээр бусад хүүхдийн асран хамгаалагчдын хандлагад эерэг өөрчлөлт гарч байгаа нь ажиглагдаж байна.

¹⁸ БСШУС-ын сайдын А/155 дугаар тушаал, 2018

ДӨРӨВ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИСС

Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг бага балчир насанд нь илрүүлэн даруй хөгжлийн дэмжлэгт хамруулах талаарх олон улсын чиг хандлага, Монгол улсад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг төр засгаас дэмжиж, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь хүргэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд хамруулах зорилго бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг байгуулах шийдвэрийг гаргасан болно. Комисс байгуулагдах хүртэл 0-16 настай хүүхдийн асуудлыг насанд хүрэгчдийн адилаар Эмнэлэг хяналтын комиссын хурлаар оруулан хөгжлийн бэрхшээлийг нь тодорхойлж, халамжийн асуудлуудыг шийдвэрлэж ирсэн. Харин Комисс байгуулагдсанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, оропцоо, хөгжлийн дэмжлэг, боловсролд хамруулахад томоохон дэвшил гарч байгаа юм.

4.1 Комиссын үйл ажиллагаа

Салбар комисс нь аймаг, дүүрэг бүрд эмч, боловсролын ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш, нийгмийн ажилтан, халамжийн ажилтан зэрэг албан тушаалтан тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйлчилгээнд хамруулах, холбогдох байгууллага, салбаруудын уялдаа хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий мэргэжилтнүүдийн баг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1-д "0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тогтооно", 37.3-д "37.2.1-д заасан Комисс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана, мөн энэхүү Комисс нь орон тооны бус Салбар комисстой байна" гэж заасны дагуу Комисс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын бүтцэд 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн (анх 2014 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын А/31 дүгээр тушаалаар Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн /хуучин нэрээр/ бүтцэд 6 орон тоотойгоор ажиллаж байсан) ажиллаж байна.

Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 200 дугаар тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-ийг баталсан. Энэхүү дүрэмд Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны Комисс, аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дэргэд орон тооны бус Салбар комисс тус тус ажиллана гэж заасан.

4.1.1 Комисс, Салбар комисстой холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 37 дугаар зүйл
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн 14.2 ...бүх шатны боловсролын байгууллага нь энэ хуулийн 37.2.1-д заасан комиссын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлэх.
- Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 200 тоот тогтоолын хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"
- Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын тавдугаар хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам"
- Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хэлс олгох журам" зэргийг үйл ажиллагаандaa баримтлан ажилладаг.

4.1.2 Комиссын зорилго:

"0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавихад" оршино.

Бүдүүвч 9: Комиссын бүтэц





Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллаж буй Комисс нь дарга, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүдтэй байх ба дараах чиг үүрэгтэй:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын салбар дундын уялдаа холбоог хангах;
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, хөгжүүлэх арга аргачлал боловсруулах, үйл ажиллагаанд ашиглах маягт заавар боловсруулах;
- Салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдтэй байгууллагын салбар дундын уялдаа холбоог хангах;
- Салбар комиссын шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;
- Салбар комиссын гишүүн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хангахад анхаарах;
- Салбар комиссын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагаас шаардах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар бүртгэл, тайлан мэдээллийг нэгтгэх, тайлاغнах, олон нийтэд мэдээлэх;
- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, зөв ойлголт нийгэмд төлөвшүүлэх үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

4.2 Салбар комисс

Орон тооны бус Салбар комиссыг "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-ийн 2.3, 2.4, 2.5-д заасны дагуу аймаг, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна.

Салбар комисс нь тухайн аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, хөгжлийг дэмжих зорилготой. Энэ зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, эрхийг хангах чиглэлээр орон нутгийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар дундын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдаа холбоог сайжруулах;
- Тухайн орон нутгийн Салбар комиссын хуралдаанд ирсэн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл, тоо мэдээг гаргаж, Комисс болон аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргэх;
- Хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах, үр дүнд хяналт тавих;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч наарт зөвлөн туслах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтөд дүгнэлт хийж, сургалтын байгууллагатай эргэх холбоотой ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтийн дунд зөв хандлага бүрдүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах.



4.2.1 Салбар комиссын эрх, үүрэг

Салбар комиссын эрх:

- Тухайн бүс нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтооно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах асуудлаар дүгнэлт гарган холбогдох үйлчилгээнд зуучлах, шаардлагатай бол холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлнэ.

Салбар комиссын үүрэг:

- Сар бүр 2-оос дээш удаа эзлжит хурал зохион байгуулна. Шаардлагатай бол уг хурлыг алслагдсан сум, багт очиж зохион байгуулна.
- Салбар комисс нь хүүхдийн асуудлыг хуралдаанаар авч хэлэлцэхдээ, тухайн хүүхэд болон эцэг, эхийг (асран хамгаалагч, дэмжлэг үзүүлэгч) нь заавал байлцуулж, санал хүсэлтийг нь сонсоно. Хүүхэд өөрөө оролцох болмжгүй тохиолдолд, Салбар комиссын нарийн бичгийн дарга хүүхдийн гэрт нь очиж амьдрал ахуйтай нь танилцан, хурал дээр танилцуулна.
- Салбар комисс нь хүүхэд бүр дээр Хувийн хэрэг нээж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулахаар шийдвэрлэсэн дүгнэлтийн талаар тэмдэглэл хөтлөх бөгөөд гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- Салбар комисс нь үйл ажиллагааны тайлан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллүүдийг улирал бүрийн дараагийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг 12 дугаар сарын 10-ны дотор Комисст хүргүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илүү нарийн мэргэжлийн хөгжлийн үнэлгээнд хамруулах, өвчин эмгэгийн онош нь зөв эсэхийг нягтлан тодруулах шаардлагатай бол мэргэжлийн байгууллага, холбоо болон комисст хүсэлт гаргана.



4.2.2 Салбар комиссын гишүүдийн ажлын чиг үүрэг

4.2.2.1 Салбар комиссын дарга

Нийгмийн бодлого/хөгжлийн хэлтсийн дарга: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

- Нэгжийн эрх, үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, удирдлага, арга зүйгээр гишүүдийг хангаж ажиллах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц бодлогыг нийслэл, аймаг, орон нутагт хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах
- Салбар комиссын гишүүдтэй гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
- Салбар комиссын үйл ажиллагааны үр дүнг тооцох, тулгамдаж буй асуудлуудаар санал боловсруулан холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- Салбар комиссын зарлан хуралдуулах, хуралдааныг удирдах, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод зохион байгуулалтын асуудлыг хариуцах
- Салбар комиссын хуралдаан, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд холбох, хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах, чиглэл өгөх

4.2.2.2 Салбар комиссын нарийн бичгийн дарга

Салбар комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, гишүүдийг мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, төлөвлөгөө, тайлан бэлтгэх, бичиг хэрэг хетлөх, бүртгэх, хадгалах.

- Салбар комиссын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх
- Хурлаар орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийг хетлөх, хадгалах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн хэрэг хетлөх



- Салбар комиссын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан нэгтгэх, холбогдох газарт зохих хугацаанд нь хүргүүлэх
- Салбар комиссын хуралдаанаар үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик тоон мэдээллийг нэгтгэх
- Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх.

4.2.2.3 Эмч (хүүхдийн эмч, мэдрэлийн эмч, сэтгэцийн эмч)

Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх болон эрүүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээнд хамруулах, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, сэргээн засах талаар заавар удирдамж боловсруулах.

- Хүүхдийн хөгжлийг үнэлж, хоцрогдол, бэрхшээлийг тогтооход оролцох
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, Салбар комиссын шийдвэрийн маягтын холбогдох хэсгийг хөтлөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, сэргээн засалтын тохирох үйлчилгээнд холбон зуучлах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
- Хүүхэдтэй ажиллах арга зүй, заавар, зөвлөмжийг эцэг эх, асран хамгаалагч, багш нарт өгөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх бодлого, орчин, нөхцлийг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж санал оруулах
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, нөлөөллийн ажил хийх
- Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр Салбар комиссын гишүүд болон орон нутгийн эмч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах.



4.2.2.4 Боловсролын ажилтан

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулахад чиглэсэн шийдвэр гаргах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэг, боловсролд хамруулах орон нутгийн үйлчилгээ, нөөц боломжийг сайжруулах.

- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, тогтооход оролцох
- Салбар комиссын шийдвэрийн маягтын холбогдох хэсгийг бөглөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэг, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, тэдний онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн аргачлалыг бий болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, гэр бүл, асран хамгаалагч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд хамран суралцахад шаардлагатай сургалтын хүртээмжтэй орчин, нөхцөл бүрдүүлэх талаар боловсролын бүх шатны байгууллагатай уялдаа холбоотой ажиллах, тулгарч буй асуудлаар санал боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

4.2.2.5 Төрийн бус байгууллагын төлөөлөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдын адил сурах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхээ эдлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтийн зерэг хандлагыг төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон гэр бүл, асран хамгаалагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, тогтооход оролцох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх, хөгжлийн дэмжлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулахад сүүлийн үеийн ололт, хандлага, туршлагаас танилцуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд чиглүүлж, холбон зуучлах, хэрэгжилтэд хяналт тавих
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх зөрчигдөж буй эсэхэд хяналт тавих, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар хамтран ажиллах

- Олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар зерэг ойлголтыг төлөвшүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах

4.2.2.6 Нийгмийн ажилтан

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдын адил амьдрах, сурч хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах.

- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, тогтооход оролцох
- Хүчирхийлэл, дарамтад өртсөн болон өртөх эрсдэлд буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх, холбогдох үйлчилгээнд холбон зуучлах
- Хүүхдийн хэрэгцээ, онцлогт тохирсон хамгааллын болон халамжийн үйлчилгээнд холбон зуучлах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх
- Эрсдэлт бүлгийн хүүхэд, тэдний гэр бүлд зөвлөгөө өгөх, эцэг эх, гэр булийн гишүүд, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.
- Хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах.

4.2.2.7 Сэтгэл зүйч

Хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, сэргээн засах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжлийг дэмжих үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд мэргэжлийн чиглэлээр ажиллах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусlamж үйлчилгээ, сургалт, судалгааны чиглэлээр холбогдох нэгж байгууллагуудын мэргэжлийн уялдааг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

- Хүүхдийн хөгжлийг үнэлэх, бэрхшээлийг илрүүлж, тогтооход мэргэжлийн чиглэлээр оролцох
- Үнэлгээн дээр үндэслэн эцэг эх, гэр бүл, хүүхдийг сэтгэл зүйн тусlamж үйлчилгээнд чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, сэтгэл зүйн дотоод нөөц (эөрэг, сайн талын)-үүдийг илрүүлсний үндсэн дээр сэдлийг нэмэгдүүлж, амьдралдаа бүтээлчээр хандах хандлагыг төлөвшүүлэх, өөрөө өөртэйгөө ажиллах, хүрээлэн буй орчинтойгоо дасан зохицоход нь туслах зэргээр ажиллах арга зүй, заавар, зөвлөмжийг эцэг эх, асран хамгаалагч, багш нарт өгөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авахад шаардлагатай хүний нөөц, орчин нөхцлийг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, тулгарч буй асуудлаар санал оруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй болж болзошгүй эрсдэлт бүлгийн хүүхдийг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа, нелөөллийн ажил хийх
- Салбар комиссын гишүүд болон орон нутгийн бусад мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээнд оролцох.

4.3 САЛБАР КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Салбар комиссын үндсэн үйл ажиллагаа нь хуралдаан байна. Салбар комиссын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хуралд оролцсон тохиолдолд хурал хүчинтэйд тооцогдох ба тэдгээр гишүүдийн хариуцсан чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргана. Салбар комиссын тогтмол үйл ажиллагаа доор дурдсан дарааллаар явагдана:

- 4.3.1 Ээлжит хуралдааны бэлтгэл ажлыг хангах;
- 4.3.2 Ээлжит хуралдаан зохион байгуулах;
- 4.3.3 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох;
- 4.3.4 Байнгын дэмжлэг үзүүлэх асуудал хариуцсан байгууллагад хөгжлийн дэмжлэг үзүүлж байгаа байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;
- 4.3.5 Дэмжлэг шаардлагатай хүүхдийг тогтмол хянах;
- 4.3.6 Ажлын үр дүнг Комисст тайлагнах.



4.3.1. Ээлжит хуралдааны бэлтгэлийг хангах

Салбар комисс нь дүрэмд заасны дагуу сард 2-оос доошгүй удаа, хөгжлийн бэрхшээлийг тогтоох болон дэмжлэгийн чиглэлээ тогтоох зорилготой ээлжит хуралдааныг зохион байгуулах шаардлагатай.

Ээлжит хурлыг зохион байгуулахдаа дараах бэлтгэлийг хангана.

Ээлжит хуралдаан зохион байгуулах өдрийг тогтоох:

Сар бүрийн ... болон ...-ны өдөр гэх мэтчилэн хуваарь гаргах нь зүйтэй. Зарим аймгийн хувьд, доорх хүснэгтэд тэмдэглэсний адилаар зохион байгуулах өдөр бүрээр зорилтот бүсийг сонгосон байна. Аймаг, дүүргүүд нь нөхцөл байдалдаа зохицуулан хурал зохион байгуулах өдрийг товлоно.

Ээлжит хуралдаан зохион байгуулах өдрийг мэдэгдэх:

Салбар комиссын нарийн бичгийн дарга нь бүх сум, хорооны нийгмийн ажилтанд ээлжит хурал зохион байгуулах өдрийг мэдэгдэнэ. Мөн Өрхийн эрүүл мэндийн төв, Дүүргийн ЭМТ, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон холбогдох бусад байгууллагад мэдэгдэж, ээлжит хуралдаанд орох хүүхдүүдийг ирүүлнэ.

Ээлжит хурал зохион байгуулах байр, тасалгааг бэлтгэх

Ээлжит хуралдаанаар орох хүүхэд, асран хамгаалагчид өөрсдийн дарааллыг тухтай хүлээх боломжтой зай талбайтай байвал зүгээр. Салбар комиссын хуралдааныг зорилтот суманд очиж зохион байгуулж болно.

4.3.2 Ээлжит хуралдаан зохион байгуулах

Салбар комиссын хуралдаан тогтсон цаг, байрлал, газарт зохион байгуулагдах ба иргэд, олон нийтэд Салбар комиссын хурадааны талаарх мэдээллийг урьдчилан түгээсэн байна.

Ээлжит хуралдаанд орох хүүхдүүдийн цагийн хуваарийг тоймлон гаргаж, хурлын өрөөний гадна байрлуулна. Хурлаар хэлэлцэж буй хүүхдийн байдлаас шалтгаалан удаан хүлээж болзошгүй тул хүлээлгийн цагийг богиносгоход анхаарах ба хүлээлгийн өреөтэй байх, хүүхдүүд, асран хамгаалагчийг дарааллаар тайван хүлээх боломжоор хангана.



- Салбар комиссын эмч нар тухайн хүүхдэд тавьсан онош нь хүүхдийн байдал, шинжилгээний хариутай нийцэж байгаа эсэхийг хянан, магадлана.
- Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд "Байнгын асаргаа шаардлагатай тодорхойлолт"-ыг эмч бөглөж, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан олгоно. Энэ нь байнгын асаргааны мөнгөн тусlamж авах үндсэн баримт болно.
- Тухайн хүүхэд болон асран хамгаалагчаас хүүхдийн талаар мэдээллийг асууна.
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэйн улмаас биеэр ирж оролцох боломжгүй хүүхдэд Салбар комиссын нарийн бичгийн дарга боломжтой өдрийг сонгон гэрээр нь очиж, эзлжит хуралдаанд хэлэлцэх зорилгоор тодруулга авна.
- Хүүхдийн бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн ерөнхий онцлог, хэрэгцээг тогтоохын зэрэгцээ хүүхдийн давуу тал, хийж чаддаг зүйл, хүүхдийг хөгжүүлэхийг зорьж буй танин мэдэхүй, хөдөлгөөн, бие даах чадвар, харилцаа, хөгжүүлэхийг зорьж буй танин мэдэхүй, хөдөлгөөн, бие даах чадвар, харилцаа, өдөр тутмын үйл ажиллагаа, оролцоо хэмээх 6 айг анхаарч үзэж асран хамгаалагчаас асууна.
- Хөгжлийн дэмжлэгийн шийдвэр гаргахад "Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)"-ыг ашиглах нь хамгийн тохиромжтой арга юм.
- Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоохдоо өвчний онош болон чадвар алдалтууд дээр үндэслэнэ. Хүүхдэд зайлшгүй шаардагатай тусlamж үйлчилгээнүүдийг "Шийдвэрийн маягт"-д бичиж тэмдэглэн, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан хүүхдэд олгоно. Энэхүү маягт нь хүүхдийг эрүүл мэнд, хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ, нийгмийн халамжийн тэтгэмж, хөнгөлөлт авах үндсэн баримт бичиг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулахдаа эцэг, эхийн хүүхдээ хэрхэн хөгжүүлэх талаарх санал бодлыг харгалzan үзнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Хувийн хэрэг" (Хавсралт 3)-ийг Салбар комиссын нарийн бичгийн дарга эсвэл нийгмийн ажилтан хариуцан хөтөлнө. Хувийн хэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар үндсэн мэдээлэл (хүүхдийн эцэг эх, гэр бүл, эрүүл мэндийн байдал, бие эрхтэн тогтолцоо, танин мэдэхүй, хэл яриа, хараа, сонсгол, нийгэмшихүй, оролцооны талаар)-ийг



агуулах ба тухайн хүүхдийн нөхцөл байдлын талаар бичигдсэн байна. Энэхүү Хувийн хэрэг Салбар комисст хадгалагдах ба хүүхэд дараагийн хуралдаанд ороход тухайн хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйлчилгээнд хамруулснаар гарсан өөрчлөлт, үр дүнгийн талаар тэмдэглэл хетлөн баримтжуулна.


- Эдгээр маягууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтөд хамрагдах үндсэн баримт болохын зэрэгцээ цаашид хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулахад ашиглах тул Салбар комиссын гишүүд хүүхдийн хөгжлийн явцыг үнэн зөв тогтоож, тохирсон дэмжлэг үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргана. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулахад хүүхдээ хөгжүүлэх талаар эцэг эхийн саналыг харгалзан үзнэ.

Эрүүл мэнд, сэргээн засалтын зөвлөгөө:

Салбар комисс нь хуралдаанаар орж буй хүүхдийн үзлэг шинжилгээ болон эмчилгээ хангалтгүй гэж үзвэл, асран хамгаалагчид нэмэлт үзлэг шинжилгээ, эмчилгээ, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл заслын үйлчилгээнд хамрагдахыг зөвлөнө. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагагатай хүүхдийг эрүүл мэндийн байгууллагад албан бичигтэйгээр илгээнэ.

Хөгжлийн дэмжлэг, боловсролын зөвлөгөө:

Салбар комисс нь хүүхдэд шаардлагатай хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг танилцуулж, шаардлагатай бол холбогдох байгууллагад хандсан албан бичиг гаргаж өгнө. Сургуулийн өмнөх насны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд гэрт нь ойр цэцэрлэг, сургуулийн насны сургуульд ороогүй хүүхдийг мөн гэрт нь ойр сургуулийг танилцуулна. Мөн тухайн хүүхдийг дэмжих зорилгоор дэмжлэг үзүүлэх боломжтой өөр бусад байгууллагуудыг судална. Тухайн аймаг, дүүрэг дэх нөөц бололцоо, дэмжлэгийн үйлчилгээний талаар нэгтгэсэн судалгаатай бол хүүхдийн нөхцөл байдалд тохирсон дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгоход хялбар байх болно. Салбар комисс нь хөгжлийн дэмжлэг үзүүлдэг байгууллагад хандаж тухайн хүүхдийг шаардлагатай дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах албан бичиг гаргаж өгнө.



Хүүхдийг сургуульд хамруулахад чиглэсэн зохицуулалтуудыг хийх зайлшгүй шаардлага гардаг тул Салбар комиссоос Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл урлагийн газарт хандаж “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл” байгуулахыг санал болгоно. “Хүүхдийн хувийн хэрэг” болон өмнө нь хамрагдаж байсан боловсролын байгууллагын шилжүүлгийн маягтыг асран хамгаалагчаар бөглүүлэн, Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлд очихыг зөвлөнө. Салбар комиссын гишүүдээс Сургуульд хамрагдахыг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд орж, хамтран шийдвэр гаргах нь чухал юм.

4.3.4 Байнгын дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйл явцтай танилцах, зөвлөгөө өгөх

Салбар комисс нь жилд наанадаж 1 удаа хөгжлийн дэмжлэг үзүүлж буй байгууллагад очин, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд нь үнэлгээ хийж зөвлөгөө өгнө.

“Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд орох:

Тухайн хүүхэд сургуульд хамрагдах тохиолдолд, Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газар нь Сургуульд хамрагдахыг дэмжих зөвлөлийг байгуулна. Салбар комиссын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн нь уг комиссын бүрэлдэхүүнд орж, тухайн хүүхдийг сургуульд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

Ээлжит бус хуралдааныг зохион байгуулах:

Салбар комисс нь шийдвэрлэхэд төвөгтэй хүнд тохиолдлыг сонгон, ээлжит бус хуралдааныг товлон хуралдуулж болно. Тухайлан авч хэлэлцэх шаардлагатай, дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй тохиолдлын бодит нөхцөл байдлыг нь нарийвчлан тогтоосны үндсэн дээр тухайн хүүхдийг хөгжүүлэхэд илүү тохиромжтой үйлчилгээ үзүүлэхийн тулд дэмжлэгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагатай хамтран хэлэлцэнэ.

Дараах 2 нөхцөлд тохиолдлыг сонгож болно.

- Цэцэрлэг, сургууль болон бусад хөгжлийн дэмжлэг үзүүлж буй байгууллага дахь жишээ тохиолдлыг сонгох. Ингэхдээ Салбар комиссын ээлжит хуралдааны шийдвэрээр тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа байгууллага

нь ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдлыг сонгон авна.

- Салбар комиссын ээлжит хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гарсан боловч тохирох хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдаагүй тул ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдлыг сонгон авах.

4.3.5 Дэмжлэг шаардлагатай хүүхдэд тогтмол хяналт үнэлгээ хийх


Ээлжит хурлаар орж, нийгмийн халамжийн тэтгэмж авч эхэлсэн хүүхдийг 6 сард 1 удаа ээлжит хуралдаанаар оруулна. Салбар комиссын гишүүд тухай бүрт хүүхэд болон асран хамгаалагчаас ярилцлага авах, "Хөгжлийн дэвтэр" дэх тэмдэглэгээнд дүгнэлт хийж тодруулах зэргээр явцын үнэлгээ хийн "Хүүхдийн хувийн хэрэг"-т бичиж тэмдэглэнэ.

4.3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст тайлагнах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн мэдээллийг улирал бүрийн дараагийн сарын 10-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөгөө 12 дугаар сарын 10-ны дотор Комисст хүргүүлнэ.

----- о О о -----





ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХУХДИЙН ЭРУУЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИССЫН ШИЙДВЭР

...оны ... сарын ... едөр
Шийдвэрийн дугаар
Хувийн хэргийн дугаар

...оны ... сарын /хот-/ийн сум, /дуурэг/-ын сум, /дуурэг/-ын регистрийн дугаартай
овогтой -г хөгжлийн бэрхшээлтэй болохыг оны ... сарын ... едрөөс оны ...
сарын ... едөр хүртэл тогтоов, сунгав, цуцлав.
/дугуйлж зурах/

Онош:
Хөгжлийн бэрхшээлийн төрөл:
Чадвар алдаалт:

аймаг, дуургийн
ХБХЭМБНХ-ын Салбар комиссын
дарга /.....

Гишүүд:
1.
2.
3.
4.
5.
6.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ДАМ
ТӨЛГҮҮГИ
ХУУЛБАГДҮНЭН
Гармын сээг:
20. 11. сар 22
едөр

Чадвар алдант ба тусгай хэрэгцээ

Хөгжлийн дэмжлэг, сэргээн засах үйлчилгээ

Танин мэдэхүй:

.....

Боловсрол:

.....

Хөдөлгөөн:

.....

Бие даах
чадвар:

.....

Эрүүл мэнд:

.....

Нийгэмшихүй:

.....

Нийгмийн
хамгаалал:

.....

Амьдралын
өдөр тутмын
үйл ажиллагаа:

.....

Оролцоо:

.....

a. Сургууль

.....


b. Нийгэм

.....

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯМ
ТЕАГУҮГ
ХҮҮЛБАР ҮНЭН
Гарын үсэг:
20 /8 он .../ гар 23 /дэр

Зөвшөөрсөн:
Хүүхдийн асран хамгаалагч:
/овог, наар/
/гарын үсэг/

.....



Хүүхдийн хувийн хэрэг

Дугаар

Овог Нэр

Нас Хүйс

Регистрийн дугаар

ХБХЭМБНХ-ЫН аймаг, дүүргийн Салбар
КОМИСС

Хувийн хэрэг нээсэн оны ... сарын ... өдөр




Хүүхдийн хувийн хэрэг хөтөлх зээвэр, тайлбар:

1. Хувийн хэргийг хөтжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрт нээж хөтөлнө.
 2. Хувийн хэргийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга хөтөлж, хадгална.
 3. Хувийн хэргийг цэвэр, засваргүй, нямбай хөтөлнө.
 4. Хувийн хэргийн III хэсгийг бөглөхдөө:
- Хүүхдийн ямар чадварууд алдагдсаныг бичиж тэмдэглэнэ.
- Танин мэдэхүй гэдэгт аливаа юмыг сурах, асуудал шийдэх, сэргэн боддох, тайлбарлах, тогтоох г.м.
 - Хөдөлгөөн гэдэгт биенийн том булчинг ашилан суух, зогсох, апхах, гүйх, тэнцвэр хадгалах, байрлал солих г.м.-ийг, гарын бичил булчингийн тусlamжтайгаар аяга халбагаа барьж хооллох, хувцсаа емсөх, тайлах, тоглох, бичих, зурах г.м.;
 - Бие даах чадвар гэдэгт хувцсаа өөрөө емсөх, тайлах г.м.
 - Бусадтай харилцах гэдэгт ярих, дохио зангаагаар харилцах, бусдын яриаг ойтоох г.м.;

- Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа, оролцоо гэдэгт тухайн хүүхдийн суралцах, бусадтай харилцах, нийгмийн аливаа үйл өжиллагаанд хамрагдах, оролцох үйл явцыг;
- Нийгэмшихий гэдэгт бусадтхий харилцах, гэр бүл, найз нөхөд, багш нартайгаа харилцах, бусдын бодол санаанд хариу үйлдэл үзүүлэх эрэгийг ойлгоно.

Хүүхдийн нааснаас хамааран дээрх үзүүлэлтүүд харилцан адилгүй байдгийг анхаарах хэрэгтэй.

6. Хувийн хэргийн IV хэсгийг бөглөхдөө үндсэн хөтжлийн бэрхшээлтэй Олон улсын өвчиний 10 дугаар антител (ICD-10) дахь кодтой нь бичиж, үндсэн бэрхшээлтэй хавсарсан бэрхшээлтэй "Хавсарсан бэрхшээл" гэсэн хэсэгт бичнэ.



Гарын үсэг: 20/18 он. 11 сар 2018-дөр

ХҮХДИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

II. ХҮХДИЙН ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАМГАЛАГЧИЙН МЭДЭЭПЭЛ /доонуур нь зурах/

I. ХҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог:	Хүүхдийн овог:		Хүүхдийн нэр:		Хаана байдал: Эцэг, эхийн асрамжинд Асран хамгаалагчийн Асрамжинчд /...../ Хүүхдийн юу болох Асрамжийн төвд Бусад /...../	Хэрүүл мэндийн байгууллагын хянгаанд байдаг эсэх: • Тогтолцогт хөтөлбөр • Заримдаа • Үгүй	Гэр бүлийн байдал: Гэрлэсэн Цуцалсан Гэрлээгүй	Ам бүлийн тоо: Хөтөлдөг эсэх: • Тийм • Үгүй				
	Хүйс: Эрэгтэй <input type="checkbox"/> Эмэгтэй <input type="checkbox"/>		Эхийн хэд дэх хүхэд болох									
	Хүүхдийн төрсөн он, сар, өдөр:		Эхийн хэдэн настайд терсөн:									
Регистрийн дугаар:												

Ургийн овог:	Овог:	Нэр:
Яс, үндэс:	Аймаг, хот:	Сүм, дүүрэг:
Регистрийн дугаар:		Холбоо барих уласны дугаар:
Боловсрол:	Мэргэжил:	Хөдөлмөр эрхпэлтийн байдал:
Дээд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Дунд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Бүрэн дунд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Бүрэн бус дунд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Сурь	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Гэр бүлийн бичиг хөтөлдөг эсэх:		Ам бүлийн тоо:
Гэрлэсэн	<input type="checkbox"/>	
Цуцалсан	<input type="checkbox"/>	
Гэрлээгүй	<input type="checkbox"/>	

Гарын сан: 20 18 он. 11 сар 23 өдөр
 Годижмор, Нийгмийн
 Хамгааллын яам
 Тайлут
ХУУЛЬБААНЫН
Цэцэрлэгтэй гэж онцлогдсон он, сар, өдөр:

III. Хүүхдийн одоогийн байдал

Онош: (ICD-10)

IV. Хөгжлийн бэрхшээлийн төрөл¹

- Хавсарсан бэрхшээл:
/тайлбар/
1. Харааны бэрхшээл
 2. Сонсгал, хэл ярианы бэрхшээл
 3. Хөдөлгөөний бэрхшээл
 4. Оюун ухааны бэрхшээл
 5. Сэтгэц, зан үйлийн бэрхшээл
 6. Үнадаг, татдаг
 7. Хавсарсан бэрхшээл
 8. Бусад бэрхшээл
- Танин мэдэхүй
- Хөдөлгөөн
- Бие даах чадвар
- Бусадтай харилцах
- Өдөр тутмын үйл ажиллагаа
- Нийгмийн оролцоо



¹ Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаалыг үндэслэв.

V. Салбар комиссын эхийн хурлын шийдвэр

Боловсролын үйлчилгээ:

Хурлаар орсон оны ... сарын ... өдөр

Шаардлагатай тусламж, үйлчилгээ:

Эрүүл мэндийн үйлчилгээ:

Нийгмийн хамгааллын үйлчилгээ:


Бусад:



VI. Салбар комиссын хурлаар дахин орсон тухай тэмдэглэп

№	Огноо	Онош	Комиссын шийдвэрийн биелэлт	Хүүхдийн хөгжилд гарч буй ахиц	Комиссын шийдвэр /Цаашид авах арга хэмжээ, зөвлөмж/	Үргэлжлэх хугацаа
			Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал /хаана, ямар үйлчилгээнд/:		Эрүүл мэндийн үйлчилгээ: Боловсролтын үйлчилгээ: Боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдал /хаана, ямар үйлчилгээнд/:	
1.					Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдالت /хаана, ямар үйлчилгээнд/:	

1.



№	Огноо	Онош	Комиссын шийдвэрийн биелэлт	Хүүхдийн хөгжилд гарч буй ахиц	Комиссын шийдвэр /Цаашид авах арга хэмжээ, зөвлөмж/	Үргэлжлэх хугацаа
			Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал /хаана, ямар үйлчилгээнд/:	Боловсролын үйлчилгээ:	Эрүүл мэндийн үйлчилгээ:	
2.			Боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдал /хаана, ямар үйлчилгээнд/:	Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалт /хаана, ямар үйлчилгээнд/:	Нийгмийн хамгааллын үйлчилгээ	ЖИЧ: "Салбар комиссын хурааар дахин орсон тухай тэмдэглэл" гэсэн энэ хуудас 10 ширхэг байна!

VII. Тусгай тэмдэглэл

Огноо	Тусгай тэмдэглэл:

Шилжилт хөдөлгөөний тэмдэглэл:

..... Дугаартай Хувийн хэрэгтэй овогтой-г
..... оны сарын ёдөр
..... рүү шилжүүлэв.

Салбар комиссын дарга /

..... Дугаартай Хувийн хэрэгтэй овогтой-г
..... оны сарын ёдөр
..... рүү шилжүүлэв.

Салбар комиссын дарга /

..... Дугаартай Хувийн хэрэгтэй овогтой-г
..... оны сарын ёдөр
..... рүү шилжүүлэв.

Салбар комиссын дарга /



АЙМАГ, ДУУРГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРУУЛ МЭНД, БОЛОВСРОЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИСС

САЛБАР КОМИССЫН ХУРАЛДААНД ОРСОН ХҮҮХДИЙН

БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР



САЛБАР КОМИССЫН ХУРАЛД ОРСОН ХҮХДИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТРИЙГ ХӨТЛӨХ ЗААВАР, ТАЙЛБАР:

1. Энэхүү дэвтэрт Салбар комиссын хурлаар орсон бүх хүүхдийг бүртгэнэ.
2. Бүртгэлийн дэвтрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга хөтөлнө.
3. Бүртгэлийн дэвтрийг цэвэр, засваргүй, нямбай хөтөлнө.
- 4.Өгөгдлүүдийг тэмдэглэхдээ ✓ тэмдгийг ашиглана.



Салбар комиссын хуралд орсон хүүхдийн бүртгэл

№	Обор, хэб Орхоо Хас	Хүнс 3р. 3м.	Перничийн бүртгэл	Гарынхаар, хондоод Лэндийн хэрэгжлийн бэрхшээлтэй эсэх	Хөгжлийн бэрхшээлтэй эсэх		Хөгжлийн бэрхшээлтэй эсэх	Комиссиуны/Бэлэндийн бүртгэл	Хүний экспримийн бүртгэл	Цэцэрлэг, сургуульд хамрагддаг эсэх
					Тийм	Үзүүл				

